ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

Марзатын гудамж 3А, Мөнхбулаг баг,
Есөнзүйл сум, Өвөрхангай аймаг, 62033,
Утас: (976) 9556 3930,
Цахим шуудан: tamgiingazarEzunzuil@gmail.com,
Цахим хуудас: www.Esunzuil.ov.gov.mn

2022.06.23 № 01/81

танай ____________ -ны № ______________ -т

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ

Тус суманд хэрэгжиж буй хууль тогтоомж, шийдвэрийн 2022 оны хагас жилийн биелэлтийг гаргаж хүргүүлэв.

Хавсралт 41 хуудастай.

ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

0215130157

D. My kom. A5alban bichig/zasag darga/

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Марзатын гудамж 3А, Мөнхбулаг баг,
Есөнзүйл сум, Өвөрхангай аймаг, 62033,
Утас: (976) 9556 3930,
Цахим шуудан: tamgiingazarEzunzuil@gmail.com,
Цахим хуудас: www.Esunzuil.ov.gov.mn

2022.12.20 № 01/140

танай ____________ -ны № ______________-т

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ

Тус суманд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны жилийн эцсийн биелэлтийг гаргаж хүргүүлэв.

Хавсралт 38 хуудастай.

ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

D. My kom. A5alban bichig/zasag darga/

# ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023.01.03 Мөнхбулаг

Тус сум нь Ерөнхийлөгчийн зарлиг 2, Улсын Их хурлын тогтоол 3, Монгол улсын Засгийн газрын тогтоол 62, Засгийн газрын албан даалгавар 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, журам 19, аймгийн Засаг даргын захирамж 4, нийтдээ 96 тогтоол шийдвэрийг хяналтандаа авч хувийн хэргийг нээн эзэнжүүлж холбогдох албан тушаалтанд танилцуулан биелэлтийг хангаж ажиллаж байна.

Монгол улсын шадар сайд 6 тогтоолын 10 зүйл заалт, Монгол улсын сайд ЗГХЭГ-ын даргын 9 тогтоолын 26 зүйл заалт, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 7 шийдвэрийн 7 зүйл заалт, Сангийн сайд 11 шийдвэрийн 11 зүйл заалт, Хууль зүйн сайд 3 шийдвэрийн 4 зүйл заалт, Батлан хамгаалахын сайдын 2 шийдвэрийн 2 зүйл заалт, Барилга хот байгуулалтын сайд 2 шийдвэрийн 2 зүйл заалт, Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 9 шийвдэрийн 9 зүйл заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 11 тогтоолын 11 зүйл заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 8 шийдвэрийн 8 зүйл заалт, Эрүүл мэндийн сайдын 4 шийдвэрийн 4 зүйл заалт нийт 73 тогтоолын 94 зүйл заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 26 тогтоолын 19 зүйл заалт, аймгийн Засаг даргын 4 захирамжийн 4 зүйл заалт нийтдээ 96 тогтоол шийдвэрийн 127 зүйл заалтын биелэлтийг хангаж ажиллаж аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээ, Дотоод аудитын хэлтэст хагас, бүтэн жилээр цаг хугацаанд нь тайланг хүргүүлж ажиллалаа.

Тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцон гаргахад Монгол улсын шадар сайдын 7 зүйл заалт 100%-ийн биелэлттэй, 3 зүйл заалт 90%-ийн биелэлттэй, Монгол улсын сайд ЗГХЭГ-ын даргын 18 зүйл заалт 100%-ийн биелэлттэй, 8 зүйл заалт 90%-ийн биелэлттэй байна. Мөн Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2 зүйл заалт 100%-ийн биелэлттэй, 4 зүйл заалт 90%-ийн биелэлттэй байгаа бол 1 зүйл заалт 70%-ийн биелэлттэй байна. Сангийн сайдын 7 зүйл заалт 100%, 3 зүйл заалт 90%-ийн биелэлттэй, 1 заалт 70%-ийн биелэлттэй, Хууль зүйн сайдын 4 зүйл заалт 100%-ийн биелэлттэй, Батлан хамгаалахын сайдын 2 зүйл заалт 100%-ийн биелэлттэй, Барилга хот байгуулалтын сайдын 2 зүйл заалт 100%-ийн биелэлттэй, Боловсрол, шинжлэх ухааны сайд 7 зүйл заалт 100%-ийн, 2 зүйл заалт 90%-ийн биелэлттэй, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 7 зүйл заалт 100%-ийн, 3 зүйл заалт 90% биелэлттэй, 1 зүйл заалт 70%-ийн биелэлттэй байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 8 зүйл заалт 100%-ийн биелэлттэй, Эрүүл мэндийн сайдын 3 зүйл заалт 100%, 1 зүйл заалт 90%-ийн биелэлттэй, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 19 тогтоолын 19 зүйл заалтын 16 зүйл заалт 100%, 1 зүйл заалт 70%, 2 зүйл заалт 50%-ийн, аймгийн Засаг даргын 4 захирамж албан даалгаврын 4 зүйл заалт бүгд 100% биелээд байна.

**Тогтоолын биелэлтийг хангаж ажилласны үр дүнд:**

**Монгол улсын шадар сайд**: Тендерийн урилга үр дүнг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдөрт багтаан Засаг даргаар батлуулж www.tender.gov.mn цахим хаягт

тендерийн ерөнхий төлөвлөгөө, урилга, үр дүнг тогтмол байршуулан ажиллаж байна. Мөн www.shilendans.gov.mn цахим хаягт мэдээллэж хэвшлээ.

**Монгол улсын сайд ЗГХЭГазрын дарга**: 2022 оны жилийн эцсийн байдлаар Засаг даргын Тамгын газарт 1358 өргөдөл, Ерөнхий боловсролын сургуулийн байгууллагад 9, Эрүүл мэндийн төвд 9, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 0, Соёлын төвд 22 өргөдөл нийт 1398 өргөдөл ирсэнийг холбогдох албан тушаалтанд цохолт хийлгэж, өргөдлийг хугацаанд нь 100% шийдвэрлээд байна. Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг батлан биелэлтийг жил бүр тооцон ажиллаж байна. 2022 оны сургалт сурталчилгааны биелэлт 87.2%-тай биелээд байна.

**Байгаль орчин ногоон хөгжлийн сайд:** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03-р сарын 04-ний өдрийн 07/01 дүгээр тогтоолын хавсралтаар зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг нийт 3 бүлэг 17 зорилттой ажлын хүрээнд батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Зорилтот жилийн нээлтийн арга хэмжээг 03-р сарын 22-ны өдөр зохион байгуулан иргэд, аж ахуйн нэгжүүдэд сурталчиллан ажиллалаа. 2022 онд зорилтот жилийн ажлын хүрээнд албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд нийт 7500ш мод тарьж сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажилласан байна. Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар төмөр хашааг сумын төвд 20000000 төгрөгийн төсөвт өртгөөр хийж дотор нь 1000ш мод бут тарьж ойн зурвас үүсгээд байна. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн ажлын тайланг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2022 оны 12-р сарын 16-ны өдрийн 12/02 тогтоолоор 91,5%-тай үнэлэгдээд байна.

**Хууль, зүй дотоод хэргийн сайд:** Нийгэмд түгээмэл буй архидан согтуурар гэр бүлийн хүчирхийллийн бууруулах чиглэлээр тус сумын ГХУСАЗСЗ даргат болон багийн Засаг даргатай хамтран хариуцсан сумандаа өдөр, орой эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллалаа. Үүрэг гүйцэтгэх хугацаанд зориулалтын бус газар архидан согтуурсан, олон нийтийн гудамж тайлбайд бие зассан, хог хаясан болон бусдын амгалан тайван байдлыг алдагуулсан гэх нийт 34 хэв журамын зөрчил илрүүлэн хариуцлага хүлээлгэн ажилласан. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6, 7 дугаар зүйлийг баримтлан Өвөрхангай аймгийн Засаг даргын захирамжийн дагуу "Баасан" гарагт архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх тал дээр хяналт тавьж ажилласан. Мөн 21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байх тал дээр хяналт тавин ажиллаж байна. Сумын хэмжээнд архинд донтох өвчтэй болсон этгээд өөрийн санаачилгаар эмнэлгийн байгууллагад хандаж сайн дурын үндсэн дээр эмчлүүлэх хүсэлт гаргасан болон архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлүүлсэн хүн байхгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг хоёр иргэнтэй архины хор хөнөөл болон ёс суртахууны талаар сургалт зохион байгуулж дахиж ийм зөрчил гаргахгүй байх талаар баталгаа авч ажилласан. Гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл хүлээн авах 102, гэр бүл хүчирхийллийн тусламжийн 107, хүүхдийн тусламжийн 108 дугаарыг иргэд, олон нийтэд сурталчилж, хүнсний дэлгүүрүүдийн мэдээллийн

самбарт байршуулж ажиллалаа. Есөнзүйл сумын цагдаагийн хэсгийн алба хаагчид архидан согтуурдаг хүмүүсийг Зөрчлийн тухай хуулиар архидан согтуурсан айл гэрийн амгалан тайван байдлыг алдагдуулсан дуулага мэдээлэл 18 бүртгэгдээд байна. Үүнээс 17 дуудлага мэдээлэлд арга хэмжээ тооцож ажиллалаа. Зам тээврийн осол гэмтэл жилийн эцсийн байдлаар Есөнзүйл суманд 5 бүртгэгдэж арга хэмжээг авч ажилласан. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газрын адргын баталсан магестрал замд хяналт шалгалтыг цагийн хуваарийн дагуу тогтмол хийж, хурд, гэрэл сумын гарцанд дээр буюу Улсын А/301 магстрал зам 7 хонгийн 3 хугацаанд цагийн менежментийн үүрэг гүйцэтгэж 443 жолоочид 13,269,000 мөнгө бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч, жолооч нарт хурд тохируулж явах, хамгаалах бүс тогтмол зүүх дээр санамж сэрэмжлүүлэг, боршур, гарын авлага 500 ш боршур тараан ажиллаж байна. Цаашид “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” хөтөлбөрийн хүрээнд тодорхой ажил арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Гэр бүлийн хүчирхийлэл 2 айл бүртгэгдэж одоогоор сумын хамтарсан багтай 5 кэйс нээн ажиллаж байна.

Улсын их хурал, Засгийн газрын тогтоолын биелэлтийн дундаж 95,2%, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Аймгийн Засаг даргын шийдвэрийн биелэлтийн дундаж 96,5 хувьтай биелж сумын нэгдсэн дүнгээр 94,3 хувиар биелсэн байна. Суманд хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн тайланг жил бүр Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж хэвшээд байна.

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН БИЧСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЕСӨНЗҮЙЛ СУМ

# ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

МӨНХБУЛАГ
2022 он

# ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ

2022.12.14 Мөнхбулаг

| № | Холбогдох эрхзүйн акт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Он, сар, өдөр | Дугаар | Хяналтанд авсан заалтын | | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжилтийн явц /хувь/ |
| | | | Д/д | Дугаар | | |
| | **Нэг. Монгол улсын шадар сайд** | | | | | |
| | **1.е.Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 1 | 2021.12.01 | 359 | 1 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 2 | 2021.02.10 | 29 | 2 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 3 | 2018.04.06 | 68 | 3 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 4 | 2018.01.24 | 20 | 4 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 5 | 2011.11.09 | 311 | 5 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 6 | 2009.04.01 | 93 | 6 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 7 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 8 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 9 | 4 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 10 | 5 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | | **97%** |
| | **Хоёр. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга** | | | | | |
| | **2.б.Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |
| 7 | 2019.02.01 | 21 | 11 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 8 | 2011.05.13 | 22 | 12 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **100%** |
| | **2.е. Монгол улсын засгийн газрын тогтоол** | | | | | |
| 9 | 2021.10.13 | 315 | 13 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 10 | 2018.08.22 | 258 | 14 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 15 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 16 | 3 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 17 | 4 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 18 | 6 | | Хэрэгжих шатандаа 100% |
| | | | 19 | 7 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 20 | 9 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 21 | 10 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 11 | 2018.02.14 | 50 | 22 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 12 | 2018.05.23 | 138 | 23 | 1 | | Хэрэгжих шатандаа 100% |
| 13 | 2009.05.14 | 143 | 24 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 14 | 2005.04.01 | 67 | 25 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | | **96,2%** |
| | **2.з. Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 15 | 2017.10.26 | 01 | 26 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 27 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 28 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 29 | 4 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 30 | 5 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 31 | 6 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 32 | 7 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 33 | 8 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 34 | 10 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 35 | 11 | | Бүрэн хэрэгжсэн 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 36 | 12 | | Хэрэгжих шатандаа 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **96,3%** |
| | **Гурав. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд** | | | | | |
| | **3.а. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |
| 16 | 2021.09.30 | 03 | 37 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 17 | 2010.04.14 | 63 | 38 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **90%** |
| | **3.б. Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |
| 18 | 2010.05.20 | 24 | 39 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **70%** |
| | **3.е. Монгол улсын засгийн газрын тогтоол** | | | | | |
| 19 | 2018.06.20 | 189 | 40 | 3 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 20 | 2017.03.20 | 98 | 41 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 90% |
| 21 | 2013.03.22 | 106 | 42 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 22 | 2005.03.09 | 44 | 43 | 6 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **95%** |
| | **Дөрөв. Сангийн сайд** | | | | | |
| | **4.е. Монгол улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 23 | 2021.02.17 | 41 | 44 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 24 | 2021.02.17 | 43 | 45 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 25 | 2020.05.06 | 163 | 46 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 26 | 2020.02.28 | 78 | 47 | 8 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 27 | 2019.01.09 | 9 | 48 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 28 | 2019.01.09 | 7 | 49 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 29 | 2019.01.09 | 6 | 50 | 2.1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 30 | 2019.12.25 | 472 | 51 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 31 | 2016.01.04 | 15 | 52 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | | **96,6%** |
| **4.ж Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | | |
| 32 | 2022.03.16 | 16 | 53 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 33 | 2022.02.09 | 99 | 54 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **85%** |
| | **Тав. Хууль зүй дотоод хэргийн сайд** | | | | | |
| | **5.б.Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |
| 34 | 2016.11.03 | 51 | 55 | 2 | | Хэрэгжих шатандаа 100% |
| **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | | **100%** |
| | **5.е. Монгол улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 35 | 2020.03.25 | 106 | 56 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 57 | 2 | | Хэрэгжих шатандаа 100% |
| 36 | 2017.02.01 | 46 | 58 | 1 | | Хэрэгжих шатандаа 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **100%** |
| | **Зургаа. Батлан хамгаалахын сайд** | | | | | |
| | **6.е. Монгол улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 37 | 2022.03.06 | 120 | 59 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 38 | 2021.07.28 | 220 | 60 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **100%** |
| | **Долоо. Барилга, хот байгуулалтын сайд** | | | | | |
| | **7.е. Монгол улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 39 | 2019.08.14 | 325 | 61 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 40 | 2016.01.04 | 10 | 62 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **100%** |
| | **Найм. Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд** | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 8.е. Монгол Улсын Засгийн газрын тогтоол | | | | | |
| 41 | 2022.11.02 | 392 | 63 | 5.1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 42 | 2022.08.24 | 314 | 64 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 43 | 2022.01.05 | 07 | 65 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 44 | 2021.08.11 | 237 | 66 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 45 | 2021.02.24 | 47 | 67 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 47 | 2021.01.20 | 18 | 68 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 48 | 2020.03.18 | 96 | 69 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 49 | 2020.04.15 | 139 | 70 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 50 | 2006.08.16 | 194 | 71 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **97,7%** |
| | **Ес . Хүнс , хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд** | | | | | |
| | **9.е. Монгол Улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 51 | 2022.03.16 | 118 | 72 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 52 | 2022.03.02 | 92 | 73 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 53 | 2022.02.16 | 74 | 74 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 54 | 2022.02.23 | 81 | 75 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 55 | 2021.07.28 | 221 | 76 | 2.1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 56 | 2020.03.25 | 113 | 77 | 1 | | Хэрэгжих шатандаа 100% |
| 57 | 2020.01.29 | 34 | 78 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 58 | 2019.05.01 | 185 | 79 | 4 | | Хэрэгжих шатандаа 100% |
| 59 | 2019.04.17 | 156 | 80 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 60 | 2017.09.22 | 278 | 81 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **94%** |
| **9.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | | |
| 61 | 2021.08.31 | 49 | 82 | | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **100%** |
| | **Арав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** | | | | | |
| | **10.е. Монгол Улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 62 | 2021.06.23 | 173 | 83 | 3 | | Хэрэгжих шатандаа 100% |
| 63 | 2021.03.10 | 58 | 84 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 64 | 2019.03.21 | 111 | 85 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 65 | 2019.01.03 | 57 | 86 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 66 | 2016.12.21 | 200 | 87 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 67 | 2017.01.02 | 31 | 88 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 68 | 2017.12.13 | 340 | 89 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 69 | 2018.01.03 | 4 | 90 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **100%** |
| | **Арван дөрөв. Эрүүл мэндийн сайд** | | | | | |
| | **14.е. Монгол улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 70 | 2021.03.17 | 67 | 91 | 2 | | Хэрэгжих шатандаа 100% |
| 71 | 2015.08. 31 | 353 | 92 | 3 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 72 | 2017.08.09 | 225 | 93 | 3 | | Хэрэгжих шатандаа 100% |
| 73 | 2017.01.18 | 24 | 94 | 2 | | Хэрэгжих шатандаа 100% |
| | **Биелэлтийн дүн /хувь/** | | | | | **97,3%** |
| **Нийт хувь** | | | | | | **95,2%** |

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ

## ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ДҮН

2022.12.14

Мөнхбулаг

| | | Бүгд | Үүнээс | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол улсын шадар сайд | Монгол улсын сайд ЗГХЭГ-ын дарга | Байгаль орчин ногоон хөгжлийн сайд | Сангийн сайд | Хууль зүйн сайд | Батлан хамгаалахын сайд | Барилга хот байгуулалтын сайд | Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | Эрүүл мэндин сайд |
| Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо | | 73 | 6 | 9 | 7 | 11 | 3 | 2 | 2 | 7 | 11 | 8 | 4 |
| Хяналтанд авсан нийт зүйл заалтын тоо | | 94 | 10 | 26 | 7 | 11 | 4 | 2 | 2 | 7 | 11 | 8 | 4 |
| | Бүрэн хэрэгжсэн 100% | 69 | 7 | 18 | 2 | 7 | 4 | 2 | 2 | 9 | 7 | 8 | 3 |
| Үүнээс | Хэрэгжих шатандаа 90% | 22 | 3 | 8 | 4 | 3 | - | - | - | - | 3 | - | 1 |
| | Хэрэгжилт хангалтгүй 70% | 3 | - | - | 1 | 1 | - | - | - | - | 1 | - | - |
| | Хэрэгжээгүй 0% | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Хугацаа болоогүй | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Тасарсан | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Зохион байгуулалтаас | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Хөрөнгө дутагдсанаас | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Биелэлтийн дүн /хувь/ | | 95,2% | 97% | 96,9% | 90% | 94,5% | 100% | 100% | 100% | 97,7% | 94,5% | 100% | 97,5% |

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

МЭДЭЭ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ

ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ШИЙДВЭРИЙН
2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2022.12.14

Мөнхбулаг

| № | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Биелэлт | Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. Монгол улсын шадар сайд** | | | | | |
| **1.е.Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 1 | 1 | Жагсаалт батлах тухай 2021-12-01 Дугаар №359<br>4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай. | Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллаж байна. | 100% | |
| 2 | 2 | Түр хороо байгуулах тухай 2021.02.10 №29<br>4. Түр хороо, Ажлын шуурхай хэсгийг үнэн зөв, бодит мэдээллээр тухай бүр хангаж, мэдээ, мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх, нийтэд буруу ташаа, үндэслэлгүй мэдээ мэдээлэл тараахгүй байх, тараасан бол холбогдох албан | Сумын Засаг Даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/ 24 захирамжаар гамшиг ослын үед ажиллах Сургалт сурталчилгаа болон иргэдэд мэдээлэл хүргэх албан тушаалтаныг томилгоожуулж бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэдэд мэдээ мэдээллийг Esunzuil_ZDTGazar, Есөнзүйл сум ЗДТГ, Есөнзүйл Онцгой Комисс, гэсэн цахим хуудсуудаар шуурхай | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | хүргэн ажиллаж байна. Мөн мессеж модем ашиглан өрх бүрт мэдээллийг тухай цаг бүрт нь хүргэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. | | |
| 3 | 3 | Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай.<br>2018.04.06 №68<br>1.5. Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлагыг хангуулахтай холбоотой үйл ажиллагаанд өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, уялдаа, зохион байгуулалтаар хангахыг Монгол Улсын Шадар сайд, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай. | 2022 оны 2 дугаар улиралд улсын хэмжээнд нэгтсэн дохиогоор газар хөдлөлтийн болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх даддага сургалтыг сумын хэмжээнд зохион байгуулан доорх ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>1. Мөнхбулаг 1, 2, 3, 4, 5 дохиог 16 цаг 00 мунитанд өгч Сумын онцгой комисс, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон албан байгууллагын дарга эрхлэгч нарыг ковид-19 цар тахалтай холбоотойгоор байгууллага тус бүрт нь цугларуулан мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн болон мэдээлэл дамжуулах дохиог тодотгосон сумын Засаг даргын захирамжийг танилцуулан үүрэг даалгавар өгч ажиллалаа.<br>2. 16 цаг 00 минутанд Мөнхбулаг 1 камандыг серин дохиогоор өгч 16 цаг 10 минутад Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, албан байгууллагуудын төрийн албан хаагчид, нийт 296 иргэн үүнээс сурагчид 202, том хүн 94, нийт 29 авто тээврийн хэрэгсэлүүд оролцсон.<br>3. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг шалгаж аранзыг үзлэгт авлаа.<br>4. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, газар хөдөлсөн болон гал түймрийн үед ажиллах дадлага сургуулалтаар цагийн байдал өгч газар хөдлөлтийн үед хэрэглэгдэх хэрэгсэл болон байрлах байрлал, хэрхэн амь насанд гарах эрсдлийг бууруулах талаар сургалт дадлага явуулан ажиллалаа.<br>Албан байгууллага аж ахуй нэгжүүдийн галын сараа болон галын хорнуудад үзлэг шалгалтыг Хархорин сумын Онцгой байдлын газартай хамтран хяналт шалгалтыг хийж зөрчил дутагдалыг арилган ажиллалаа. | 100% | |
| 4 | 4 | Аргачлал шинэчлэн батлах тухай<br>2018.1.24 №20<br>Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг дараа оны 2 дугаар сард багтаан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д оруулан баталгаажуулж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Орон нутгийн хөгжлийн индекс тогтоох 20 дугаар тогтоолын дагуу жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдөр багтаан http://ldi.nda.gov.mn/ цахим хаяг индексийн мэдээг оруулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст индексийн мэдээг хүргүүлж байна. | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | 5 | Нийтлэг журам батлах тухай.<br>2011.11.09 №311<br>1. "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2 8.2.1-д заасны дагуу харьяа байгууллага, аж ахуйн нэгж, өөрийн аппаратад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан | Албан байгууллага бүрт дотоод хяналтын багтай болж байгууллагын дарга нарын тушаалаар баталгаажуулан жил бүр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж биелэлтийг нь ханган ажиллаж байна. Сумын зүгээс дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үүднээс хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 90% | |
| 6 | 6 | "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2009.04.01 №93 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:<br>1. Тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд (www.e-procurement.mn) цаг хугацаанд нь бүрэн тавьж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж байх | Тендерийн урилга үр дүнг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдөрт багтаан Засаг даргаар батлуулж www.tender.gov.mn цахим хаягт тендерийн ерөнхий төлөвлөгөө, урилга, үр дүнг тогтмол байршуулан ажиллаж байна. Мөн www.shilendans.gov.mn цахим хаягт мэдээллэж ажиллалаа. | 100% | |
| | 7 | 2. Захиалагч бүр жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аливаа хяналт, аудитын тайлан, дүгнэлт, иргэд болон байгууллагаас гаргасан гомдлын тоо, агуулга, шийдвэрлэсэн байдлын талаар байгууллагын самбарт нийтэлж, нийтэд ил тод хүргэж байх | Тендерийн ерөнхий төлөвлөгөөг Засаг даргаар батлуулж www.tender.gov.mn цахим хаягт оруулж яамаар батлуулан ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн баримт болон ажилд хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээллийг шилэн данс болон мэдээллийн самбар, сумын вэб сайт, сэтгүүлд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна | 100% | |
| | 8 | 3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажилтнуудын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх болон худалдан авах ажиллагааны чиглэлээрх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж байсугай. | Төрийн албан хаагчдын худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх үүднээс Худалдан авах ажиллагаа явуулах А3 сертификатгүй төрийн албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээнд А3 сертификаттай болох заалтыг оруулж өгч ажиллан. 2022 оны хагас жилийн байдлаар сумын хэмжээнд А3 сертификаттай 10 төрийн албан хаагч байна. | 100% | |
| | 9 | 4. Харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ хууль зөрчиж байгаа нийтлэг дутагдлыг арилгаж, Төрийн | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босгон үнээс дээш өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж байх | хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж байна. 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 25 ажил байгаагаас журмын дагуу харьцуулалтын аргаар 6 ажил, зөвлөх үйлчилгээний аргаар 1, шууд гэрээ байгуулах 18 ажил төлөвлөгөөний дагуу тендерүүд зарлагдаж эхний улиралд 12 ажил гэрээ байгуулан ажиллаж байна. | | |
| | 10 | 5. Захиалагч бүр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллан, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай бүрт мөн хуулийн 49.2-т заасан баримт бичиг, материалыг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж байсугай. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн баримт бичгийг Засаг даргын Тамгын газрын архивт хүлээн авч архивийн нэгж үүсгэн данс бүртгэлд оруулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан бүх тендерийг зарлан ажлыг гүйцэтгүүлэн ажилласан. 2022 оны эхний хагас жилд 12 ажлыг зарлан гэрээ байгуулан хуулийн 49.2 дахь заалтын дагуу архивласан | 100% | |
| Хэсгийн дундаж 98.4% | | | | | |
| **Хоёр. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга** | | | | | |
| **2.б. Улсын их хурлын тогтоол** | | | | | |
| 7 | 11 | Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай<br>2019.02.01 №21<br>2.Төрийн захиргааны албан хаагчид 2019 онд олгох зэрэг дэвийн нэмэгдлийг баталсан төсвийн хэмжээнд багтаан зохицуулж, цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай. | Жил бүрийн төсөвт төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг тусган хууль тогтоомжийн дагуу зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна. Мөн 2022 онд хууль тогтоомж дахь шаардлагыг хангасан 6 төрийн жинхэнэ албан хаагч зэрэг дэвийг ахиулан олгож зэрэг дэвийн нэмэгдлийн цалинг олгон ажиллаж байна. | 100% | |
| 8 | 12 | Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай<br>2011.05.13 №22<br>2.Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж, тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын | 2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/50 дугаартай “Онцгой комиссын бүрэлдэхүүн томилж, ажиллах журам батлах тухай”, А/51 захирамжаар “Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн анги байгуулах тухай”, А/52 дугаар захирамжааар “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын нэгдсэн тохиогоор ажиллах тухай”, А/56 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах тухай болон сайн дурын бүлэг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай. | байгуулах тухай", захирамжаар гамшгийн ослийн үед урьдчилан сэргийлэх, ажиллах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг тус тус батлан онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгууллаа. Мөн Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, байгууллагууд мөн үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан тухай бүр хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | |
| **2.е. Монгол улсын засгийн газрын тогтоол** | | | | | |
| 9 | 13 | **Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай 2021.10.13 №315**<br>3. Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | 2021 оны аж ахуйн нэгжийн тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийнсумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/147 тоот захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 2021 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл зохион байгууллаа. Сумын хэмжээнд нийт 38 байгууллага, аж ахуйн нэгж, 22 хувиараа хөдөлмөр эрхлэгчийг тус программд шивж оруулсан. | 100% | |
| 10 | 14 | Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай<br>2018.08.22 №258<br>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай<br>Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, сургал тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр | Байгууллага тус бүр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн актууд, дүрэм журам болон бусад тогтоол шийдвэрүүдийн нэгдсэн цахим сантай болж, шинээр гарсан тушаал шийдвэрүүдийг цаг хугацаанд нь албан хаагчиддаа танилцуулан мөрдөн ажиллаж байгаа бөгөөд мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна. Төрийн албан хаагчдийн сахилга хариуцлага дэг журмыг чангатгах үүднээс албан хаагчдад байгууллагын дотоод журмыг дахин танилцуулж гарын үсгийн баталгаа авч мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сахилга хариуцлага, ёс зүйн зөрчилгүй ажиллах талаар ажлыг тусган хэрэгжилтийг нь тооцон ажиллаж байна. Мөн төрийн албан хаагч бүрээр Төрийн албаны манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, төрийн хууль ёсыг чанд сахин аймаг орон нутгийнхаа хөгжлийн төлөө эрдэм чадлаа | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх | зориулж, өөрийн болон байгууллага, хамт олныхоо нэр төр, соёлч байдлыг эрхэмлэн иргэдийг ялгаварлахгүйгээр ижил тэгш, зөв шударга харьцаж, ажлын цагийг цалгардуулж хийдүүлэхгүй, бүтээмжээ нэмэгдүүлж, аливаа хууль бус дарамт шахалтад автахгүй, үйлдэхгүй, албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байхаа илэрхийлж баталгаа гаргуулан аваад байна. Мөн 2022 оны жилийн эцсийн байдлаар ёс зүй болон сахилгын зөрчил илэрсэн байдал илрээгүй байна. | | |
| | 15 | 2. Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 09 дүгээр сарын 1 -ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх | Есөнзүйл сумын төрийн байгууллагуудад 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 1398 өргөдөл, санал ирсэнийг хүлээн авч ажиллалаа. Нийт өргөдлөөс хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй 1398 өргөдөл буюу 100%-ийг нь хугацаанд нь шийдвэрлэж хариу өгч ажиллалаа. Ирсэн өргөдлөөс нийгмийн халамжтай өргөдөл хамгийн өндөр хувийг эзэлж байна. Байгууллагын үйл ажиллагаатай болон материал мөнгөн тусламж хүссэн өргөдөл ирээгүй байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажиллаж байна. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөөг өгөн ажиллаж байна. | 100% | |
| | 16 | 3.Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах | Төрийн албан хаагч бүрийн ажлын байрны дүн шинжилгээ хийж төсвийн шууд захирагч нарын тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Байгууллага тус бүр ажиллагсдын албан тушаалын тодорхойлолтыг ажлын давхардал, хийдэлгүйгээр загварчлан боловсруулсан бөгөөд ажиллагсад албан тушаалын | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажиллаж байна. | | |
| | 17 | 4.Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн албыг бэхжүүлэх | Тус сумын Засаг даргын Тамгын газарт 2022 оны хагас жилийн байдлаар Санхүү албаны дарга, Хүнс, ЖДҮ хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн нарын сул ажлын байруудын захиалгыг Өвөрхангай аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн төрийн албаны тусгай шалтгалтыг зарлуулан ажиллаж байна. 2022 онд Санхүү албаны дарга, Нийгмийн бодлогын мэргэжилтэн төрийн албаны тусгай шалгалтанд тэнцэн тухайн албан тушаалд томилогдон ажиллаж байна. | 100% | |
| | 18 | 6.Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх. | Жирэмсэний болон амаржсаны амралттай байгаа 1, удирдлагын академийн " Төрийн албанд ан тлмилогдсогы богино хугацааны мургалтанд 1, богино хугацааны сургалтанд 2, албан хаагч хамрагдаж ажиллаж байна. | 100% | |
| | 19 | 7.Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажпын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хэрэглэх, хадгалах, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох | Албан байгууллагуудын дотоод журманд ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажпын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хэрэглэх, хадгалах, ашиглахыг хориглож зөрчсөн тохиолдолд ямар арга хэмжээ тооцохыг тусган оруулж тухай бүр хяналт тавин ажиллаж байна. | 90% | |
| | 20 | 9.Төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж түүнд тавих хяналтыг | Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын цагийг бүртгэн дотоод журамд шалтгаангүй 8 цаг тасалсан бол сануулах, шалтгаангүй 24 цаг тасалсан бол ажлаас | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сайжруулах | халах заалтыг оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн төрийн үйлчилгээний албан байгууллагууд албан хаагчдын цаг бүртгэлийн дэвтрээр бүртгэн ажлын цагийг баримтлуулах үр бүтээлтэй ажиллах тал дээр хяналт тавин ажиллаж байна. | | |
| | 21 | 10.Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах | Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага тооцож ажиллах талаар байгууллагын дотоод журманд тодорхой заалтуудыг оруулан мөрдөн биелэлтийг нь ханган ажиллаж байна. Сумын хэмжээнд зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна. | 100% | |
| 11 | 22 | Үндэсний хөтөлбөр батлах тухай. 2018.02.14 №50<br><br>Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | 2022 онд жилийн эцсийн байдлаар нийт 543 актаар сангаа баяжуулж одоогоор хууль тогтоомжийн бүртгэлийн лавламжийн санд 7128 эрх зүйн акт байна. Мөн 287 зүйл заалтаар өөрчлөлт хөдөлгөөнийг хийсэн байна. Шинээр гарсан хууль тогтоомжууд, тогтоол шийдвэрүүд болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийг бүртгэл хяналтанд авч хувийн хэрэгжүүлж холбогдох албан тушаалтанд танилцуулж ажиллаж байна. Холбогдох дээд байгууллага болон бусад байгууллагаас ирсэн хугацаатай болон хариутай бичгүүдийг тухайн цаг хугацаанд нь хариуг нь хүргүүлж ажиллаж байна. Төсвийн байгууллагын бичиг хэрэг, тушаал шийдвэрүүдэд хяналт тавин ажиллаж байна.<br><br>❖ 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар сумын Засаг даргын 154 захирамж гарсанаас үйл ажиллагааны чиглэлээр гаргасан захирамж 137 боловсон хүчний чиглэлээр 17 захирамж гаргасан байна.<br>❖ Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлээр гарсан тушаал 4, боловсон хүчний чиглэлээр 21 тушаал гарж тухайн цаг бүрт нь боловсруулалт хийн хэрэгжүүлэн ажиллаж байна. | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ❖ Хууль зүйн чиглэлээр 2022 оны хууль эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>❖ Хууль тогтоомжийг иргэд, төрийн албан хаагчдын дунд хийсэн сургалт сурталчилгааны ажлыг сумын ЗДТГ-ийн "Esunzuil_Zdtgazar", Есөнзүйл сум ЗДТГ, сумын онцгой Комисс, Есөнзүйл сум ГХУСЗ зэрэг цахим хуудсанд тогтмол мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. Цахим хуудсанд 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 15 агуулгын хүрээнд мэдээ мэдээлэл, гарын авлагыг бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан бол монгол улсын хуулиудтай холбогдох заалт, арга хэмжээ, зохион байгуулж буй үйл ажиллагаа зэргийг иргэдэд цахим хуудсаар тогтмол хуваалцаж ажиллалаа.<br>❖ Энэ улиралд нийтлэг хэм хэмжээ тогтоосон захирамж болон захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж гараагүй. | | |
| 12 | 23 | Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай.<br>2018.05.23 №138<br>2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй. | Төрийн албан хаагчдад ажлын 8 цагийн хүрээнд олон нийтийн сүлжээ онлайн тоглоом болон видео сан бүхий сайтад нэвтрэхгүй байхыг зөвлөж тогтоолын биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газарт албаны мэйл хаяг нээн албан бичгийг дээд байгууллагатай солилцон ажиллаж байна. | 100% | |
| 13 | 24 | Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай.<br>2009.05.14 №143<br>2. "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай | Төсвийн бүх байгууллага ил тод байдлыг журмын дагуу биелэлтийг ханган ажиллаж байна. Байгууллага бүр ил тод байдлын самбар ажиллуулж байна. Төрийн сан төсвийн мэдээ тайланг тогтмол шилэн дансанд байршуулан ажилласан. Засаг даргын Тамгын газрын Esunzuil ZDTGazar facebook хаяг, Есөнзүйл сум ЗДТГ, Ysunzuil ЕМТ, Есөнзүйл сумын ЕБС, Есөнзүйл цэцэрлэг зэрэг цахим | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хуудсуудаар цаг үеийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэж ажиллаж байна. | | |
| 14 | 25 | Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 2005.04.01 №67<br>1.б. Иргэдээс амаар бичгээр болон цахим сүлжээ, радио телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр түүнчлэн тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, шийдвэрлэлтийн явцыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг нийтэд зарлан сурталчилах зэрэг ажлыг дээрх журамд тусган хэрэгжүүлэх | Есөнзүйл сумын төрийн байгууллагуудад 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 1398 өргөдөл, санал ирсэнийг хүлээн авч ажиллалаа. Нийт өргөдлөөс хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй 1398 өргөдөл буюу 100%-ийг нь хугацаанд нь шийдвэрлэж хариу өгч ажиллалаа. Ирсэн өргөдлөөс нийгмийн халамжтай өргөдөл хамгийн өндөр хувийг эзэлж байна. Байгууллагын үйл ажиллагаатай болон материал мөнгөн тусламж хүссэн өргөдөл ирээгүй байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажиллаж байна. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөөг өгөн ажиллаж байна. | 100% | |
| **2.з. Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 15 | 26 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017.10.26 №01<br>Шударга ил тод хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч байна.<br>Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах. | Төрийн албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйн зөрчилгүй ажиллах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх талаар, тодорхой заалтыг тусгуулан хэрэгжилтийг нь хагас жилээр дүгнэн ажиллаж байна. Мөн төрийн албан хаагч бүрээр Төрийн албаны манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, төрийн хууль ёсыг чанд сахин аймаг орон нутгийнхаа хөгжлийн төлөө эрдэм чадлаа зориулж, өөрийн болон байгууллага, хамт олныхоо нэр төр, соёлч байдлыг эрхэмлэн иргэдийг ялгаварлахгүйгээр ижил тэгш, зөв шударга харьцаж, ажлын цагийг цалгардуулж хийдүүлэхгүй, бүтээмжээ нэмэгдүүлж, аливаа хууль бус дарамт шахалтад автахгүй, үйлдэхгүй, албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байхаа илэрхийлж баталгаа гаргуулан аваад байна. | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 27 | 2.Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх | Есөнзүйл сумын Авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 100%-тай байна. | 100% | |
| | 28 | 3.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах | Өргөдөл гомдолын талаарх шийдвэрлэлт дээр алдаа тудагдал гаргажажилласан аслбан хаагч жилийн эцсийн байдлаар байхгүй байна. Есөнзүйл сумын төрийн байгууллагуудад 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 1398 өргөдөл, санал ирсэнийг хүлээн авч ажиллалаа. Нийт өргөдлөөс хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй 1398 өргөдөл буюу 100%-ийг нь хугацаанд нь шийдвэрлэж хариу өгч ажиллалаа. Ирсэн өргөдлөөс нийгмийн халамжтай өргөдөл хамгийн өндөр хувийг эзэлж байна. Байгууллагын үйл ажиллагаатай болон материал мөнгөн тусламж хүссэн өргөдөл ирээгүй байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажиллаж байна. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөөг өгөн ажиллаж байна. | 100% | |
| | 29 | 4.Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих | Ажлын цагаар төрийн албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэх, үүрэгт ажлаа чанартай сайн гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж бусад хувь хүн өөрийн хөгжих талаас нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд ажлын байран дээр олон нийтийн цахим сүлжээг ашиглахгүй байх дэг журмыг өөрдсийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 90% | |
| | 30 | 5.Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, | Төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар байгууллагын дотоод журманд тодорхой заалтуудыг оруулан биелэлтийг нь ханган ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд Тухайн сургууль нь 100% мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан ба хамгийн багадаа 4 дэх жилдээ ажиллаж байгаа багш, | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх | ажиллагсад байгаа бөгөөд төрийн албан хаагчдыг тогтвор, суурьшилттай ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллаж байна. Мөн Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүд мэргэжлийн шаардлага хангасан албан хаагчдыг хууль тогтоомжийн дагуу ажиллуулан үйл ажиллагаа явуул байна. | | |
| | 31 | 6.Албан тушаалтны сахилга. хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах | Албан тушаалтан бүрээр сахилга, хариуцлагыг чангатгах, өндөржүүлэх талаар баталгаа гаргуулж уриалгад нэгдүүлэн ажиллаж байна. Мөн Удирдах ажилтаны улсын зөвлөгөөнөөс гарсан андгайг албан хаагч бүрээр өргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.Тухайн албан байгуулллага бүр дотоод хяналтын нэгж нь улирал бүр байгууллагын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж гарсан алдаа дутагдал бүрийг цаг тухайд нь засч залруулан үйл ажиллагааны гүйцэтгэл, чанарт ахиц гарган ажиллаж байна. Байгууллагын дотоод хяналтын нэгж нь улирал бүр тайлан мэдээг хүргүүлэн үнэлгээ дүгнэлт авч ажиллаж байна. | 100% | |
| | 32 | 7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тоггоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах | 2022 оны Худалдан авах ажиллагааны Ерөнхий төлөвлөгөөг боловсруулж төлөвлөгөөнд тусгагдсан ажилуудын тендерийг зарлаж ажлыг гүйцэтгэж байна.<br>1.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод нээлттэй зохион байгуулж, бүх худалдан авалтыг цахим тендер шалгаруулалтаар зохион байгуулж, дотоод давуу эрхийг тооцож ажилласан.<br>2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний болон төсөвт байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудасд тогтмол байршуулж тендерийн явц үр дүн, гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийг тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээллэж ажилласан.<br>3. Худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээний хороонд Сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлаас томилсон иргэний төлөөллийг тухай бүрд нь үнэлгээний хороонд оруулж ажилласан<br>4. Төсөвт байгууллагуудын өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем дэх хөрөнгийн бүртгэл мэдээлэл бүрэн хийгдэж, зургийг оруулах ажил хийгдэж байна.<br>5. Орон нутгийн өмчид байгууллагуудын газар эзэмших эрх нь тухайн байгууллагын хөрөнгөд бүртгэж ажилласан<br>6.Тендерийн ерөнхий төлөвлөгөөг Засаг даргаар батлуулж www.tender.gov.mn-д оруулж яамаар батлуулан ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн баримт болон ажилд хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээллийг шилэн данс болон | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн самбар, сумын вэб сайтанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна. | | |
| 33 | 8.Төрийн албаны тухай хууль тогтоомж. дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх; | Төрийн албан хаагчийн ажлын хийдэлийг арилгах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүрийн үр дүнгийн гэрээ байгуулахад нь онцгой анхаарал тавин ажиллаж байна.<br>Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд төрийн албан хаагчийн ур чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг тусган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн өөр өөрийн онцлогт нь тусган мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилтуудыг жил бүр харилцан тохирч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган биелэлтийг нь тооцон ажиллаж байна. Төрийн албан хаагчдыг дээд байгууллагаас зохион байгуулж буй цахим сургалт семинарт 100% хамруулан үр дүнг бий болгон ажиллаж байна | 100% | |
| 34 | 10.Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах. | Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэн ажиллаж байна. Өндөр дүгнэгдсэн албан хаагчийг хууль ёсны дагуу урамшууллыг олгон ажиллаж байна. Мөн албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл чанарт үнэлэлт дүгнэлт өгч ажлын чанар, гүйцэтгэлийн хувиар улирал бүр мөнгөн урамшуулал олгож байна | 90% | |
| 35 | 11.Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн еренхийлөн захирагч нарт даалгаж байна | Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж хэмнэлтийн горимыг чанд сахин төлөвлөгөөний дагуу захиран зарцуулж ажиллаж байна. 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн мөрдлөг болгон ажиллаж байна. | 100% | |
| 36 | 12.Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж байна. | Сумын хэмжээнд төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх үүднээс суманд иргэний танхим, нэг цонхны үйлчилгээг байгуулж иргэдэд төрийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100% | |
| | Хэсгийн дундаж хувь 96,9% | | | |

**Гурав. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **3а.Ерөнхийлөгчийн зарлиг** | | | |
| 16 | 37 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар №03 3.5.Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | Ерөнхийлөгчийн зарилгаар Тэрбум мод аяны хүрээнд сумын хэмжээнд нэгдэн мод тарих үйл ажиллагааг идэвхижүүлэн ажиллалаа. Жилийн эцсийн сумын хэмжээнд албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдтэй хамтран сумын хэмжээнд Улиас, халиас, бургас зэрэг 4500 гаруй модыг тарьж ажиллалаа. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 150 м урт, 6м өргөн төмөр хашааг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Алтан жолоот хүлэг ХХК-аар хийлгүүлж байршуулж нийтийг хамарсан ажлын хүрээнд мод тарих ажлын зохион байгууллаа. Мөн Байгаль орчны яамнаас зохион байгуулсан Мод бут тарих талаар цахим сургалтад хамрагдсан эргүүл шалгалтаар сумын хэмжээнд Зүүн хайрхан, Дөлгөөн хайрхан уулуудад 2 удаа яван ажиллалаа. | 90% | |
| 17 | 38 | Мод тарих үндэсний өдөр болгон зарлах тухай 2010.04.14 №63 1.Жил бүрийн 5,10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн бямба гаригийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласугай. 2. Мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут,сөөг, цэцэг тарих цаашид арчилан хамгаалах түүнийгээ амьдралын хэв маяг болгон сурталчилж ажиллахыг монгол улсын нийт ард иргэд, төрийн бүх байгууллага, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, хандивлагч нарт уриалсугай | Жилийн эцсийн байдлаар сумын хэмжээнд албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдтэй хамтран сумын хэмжээнд Улиас, халиас, бургас зэрэг 4500 гаруй модыг тарьж ажиллалаа. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 150 м урт, 6м өргөн төмөр хашааг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Алтан жолоот хүлэг ХХК-аар хийлгүүлж байршуулж нийтийг хамарсан ажлын хүрээнд мод тарих ажлын зохион байгууллаа. Мөн Байгаль орчны яамнаас зохион байгуулсан Мод бут тарих талаар цахим сургалтад хамрагдсан эргүүл шалгалтаар сумын хэмжээнд Зүүн хайрхан, Дөлгөөн хайрхан уулуудад 2 удаа яван ажиллалаа. | 90% | |
| | | **3б. Улсын Их Хурлын тогтоол** | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | 39 | "УС" үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2010.05.20 Дугаар 24<br>1.Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хэрэгжүүлэх "Ус" үндэсний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.<br>2."Ус" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай | Есөнзүйл сумын нийт 250 мянган га талбай бүхий нутаг дэвсгэрт 6 гол, 40 гаруй булаг, шинээр сүүлийн хоёр жилд гаргасан 5 худаг, цөөн тооны хөв, нуур, баянбүрд байдаг. Эдгээрээс 2022 оны жилийн эцсийн байдлаар тус сумын төвийн баруун зүүн талаар өмнөөс хойд чигт урсдаг Марзад, Хавцгайн голын эрэг, сав дагуух газрыг иргэд, төрийн албан хаагчдын оролцоотойгоор хог малын сэг зэмийг 1 удаа цэвэрлэж гаргасан хогийг нэгдсэн хогийн цэгт асгаж голын усны цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн жамаар сэргээх, хамгаалах ажлуудыг хийж гүйцэтгэсэн ажиллалаа. | 70% | |
| **3.е. Монгол улсын засгийн газрын тогтоол** | | | | | |
| 19 | 40 | Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай<br>2018.06.20 №189<br>2. Хог хаягдлын эдийн засгийн зохицуулалтыг сайжруулах, үүсгэгч нь хариуцаж, бохирдуулагч нь төлөх эко төлбөрийн эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад даалгасугай. | Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуйн нэгжүүд болон хүнсний дэлгүүрүүд, ард иргэдийн ундны ус хангагч худгууд, Засаг даргын Тамгын газрын зарын самбар, сумын цахим хаягаар, цагдаагийн хэсэг, гэх мэт газруудаар Өвөрхангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас гаргасан "Уриалга", Засгын газрын 189 дүгээр тогтоол зэргээр боршур хийж иргэдэд сурталчлах мөн уриалгыг байршуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>Мөн зорилтод бүлгийн иргэд болон аж ахуйн нэгж лбан байгууллагуудын албан хаагчдад Засгын газрын 189 дүгээр тогтоол, Уриалга, хог хаягдлын тухай хууль, байгаль орчны тухай хууль, олон удаа хэрэглэгдэх цаасан болон даавуун уутыг хэрэглэж занших, түүнийг өөрсдийн нөөц боломжоор хийж хүнсний дэлгүүрүүдээр худалдан борлуулах талаар хамтран сургалт сурталчилгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | 90% | |
| 20 | 41 | Хөтөлбөр батлах тухай<br>2017.03.20 №98<br>3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо"-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн | Сумын хэмжээнд их цэвэрлэгээг 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр зохион байгуулж ажиллалаа.<br>Үүнд: Засмал дагуу цэвэрлэсэн хог 3 тн, Даянгийн голоос хиймэл нуур хүртэл 10 тн хог хаягдал, малын сэг зэмийг зөөж нэгдсэн хогийн цэгт дарж булшиллаа.. Есөнзүйл сумын төвийн 250 гаруй айл өрхийн 90 гаруй хувь нь байгальд ээлтэй уламжлалт эко түлш болох аргалыг түлшний хэрэгцээнд тогтмол хэрэглэж байна. | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | | | |
| 21 | 42 | Журам, жагсаалт шинэчлэн болон шинээр батлах тухай<br>2013.03.22 №106<br>2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраахад шаардлагатай техник, багаж хэрэгслийг худалдан авахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гамшиг осол гарсан үед журмын дагуу хөрөнгө зарцуулан ажиллаж байна. Тус сумын 1,2,3,4-р багийн иргэдийн нийтийн хурал дээр ой хээрийн түймэр түүнээс урдчилан сэргийлэх ба хаана мэдэгдэх, гарч болзошгүй цаг хугацаа байгалийн хүчин зүйл буюу цаг агаар, авч болох өөрсдийн боломжит арга хэмжээ, сумын онцгой комиссын бүрэлдэхүүн гэх мэт мэдээ мэдээлэл, сурталчилгааг хийж багийн засаг дарга нарт үүрэг чиглэл өглөө. 2022 онд Байгаль орчны тухай хуулиуд журмын зөрчил гэмт хэргийг бууруулах зорилгоор Байгаль орчны хяналт шалгалтыг Цагдаагийн байгууллага төрийн албан хаагчтай хамтран хяналт шалгалтыг 1 удаа хийж гүйцэтгэлээ. | 100% | |
| 22 | 43 | Ногоон хэрэм дэд хөтөлбөр 2005.03.09<br>Дугаар 44<br>Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж ойн сан хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа экологийн өнөөгийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг саарулах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгоход байгаль орчин, нийгэм эдийн засгийн хөгжлийн цогц бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт тохируулан урт хугацааны турш үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол орны говь, хээрийн бүсийн заагийг бүрэн хамарсан ногоон зурвас, ногоон төгөл байгуулахад оршино. | Жилийн эцсийн байдлаар сумын хэмжээнд албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдтэй хамтран сумын хэмжээнд Улиас, халиас, бургас зэрэг 4500 гаруй модыг тарьж ажиллалаа. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 150 м урт, 6м өргөн төмөр хашааг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Алтан жолоот хүлэг ХХК-аар хийлгүүлж байршуулж нийтийг хамарсан ажлын хүрээнд мод тарих ажлын зохион байгууллаа. Мөн Байгаль орчны яамнаас зохион байгуулсан Мод бут тарих талаар цахим сургалтад хамрагдсан эргүүл шалгалтаар сумын хэмжээнд Зүүн хайрхан, Дэлгэөн хайрхан уулуудад 2 удаа яван ажиллалаа. | 100% | |
| Хэсгийн дундаж 90% | | | | | |
| **Дөрөв. Сангийн сайд** | | | | | |
| **4.е. Засгийн газрын тогтоол** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 23 | 44 | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай<br>2021.02.17 №41<br>2.Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Тус сумаас цэргийн дүйцүүлэх албанд 2022 оны хагас жилийн байдлаар цэргийн дүйцүүлэх албыг хааж буй иргэн байхгүй байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 19 иргэн мөнгөн төлбөрийн тооцоог хийн ажиллаж байна. | 100% | |
| 24 | 45 | Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2021.02.17 №43<br>1. Монгол улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай. | Хуваарилагдсан төсвийг зүйл заалтын дагуу зарцуулахын сацуу төсвийг хэмнэх талаар авч буй арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | |
| 26 | 46 | Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай 2020.05.06 №163<br>3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай. | Сумын төсөвт байгууллагууд төрийн албаны цалингийн нэгдсэн системд нэвтрэх эрхийг аван хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулсан мэдээллийг төрийн албаны цалингийн нэгдсэн системд татан төрийн албан хаагчдын цалин хөлсийг тооцоолж цахимаар цалинг олгож эхлээд байна. | 100% | |
| 27 | 47 | Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай<br>2020.02.28 №78<br>8. Энэ онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шуурхай зохион байгуулж, | Тендерийн ерөнхий төлөвлөгөөг Засаг даргаар батлуулж tender.gov.mn-д оруулж яамаар батлуулан ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн баримт болон ажилд хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээллийг шилэн данс болон мэдээллийн самбар, сумын вэб сайтанд байршуулан ил тод байдлыг хангаж ажиллаж байна. 2022 оны тендерийн бүх үйл ажиллагааг цахимаар зарлан ил тод байдлыг хангаж ажиллалаа. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | мэдээллийг ил тод нийтэлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | | | |
| 28 | 48 | Журам батлах тухай<br>2019.01.09 №9<br>Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам.<br>1.1 Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан үндэслэлээр, мөн хуулийн 43 дугаар зүйлд заасан журмын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид цалин, урамшуулал олгоход энэ журмыг баримтална. | Журмын дагуу түр орлон гүйцэтгэж байгаа 2 албан хаагчдад урамшууллыг олгож ажиллаж байна. | 90% | |
| 29 | 49 | Журам батлах тухай<br>2019.01.09 №7<br>2.1 Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам. 1.1. Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход энэ журмыг мөрдөнө. | 2022 оны жилийн цэсийн байдлаар Засаг даргын Тамгын газрын Байгаль хамгаалагч, СӨББайгууллагын нягтлан бодогч, туслах тогооч, Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн, Засаг даргын Тамгын газрын үйчлэгч нар тэтгэвэрт гарч Төрийн албаны тухай хуульд заасны дагуу холбогдох хууль журмыг баримтлан ажиллаж байна. | 90% | |
| 30 | 50 | Журам батлах тухай<br>2019.01.09 №6<br>Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам<br>2.1 Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно | Төрийн албан хаагчдыг 2022 оны дөрөвдүгээр улиралын байдлаар нийт өссөн дүнгээр 32 албан хаагчийг дотоодын сургалтад хамаруулж 7024000 төгрөгийн томилолт, 11 албан хаагчдын 4655237 хагас жилийн үр дүнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний урамшууллыг олгоод байна. Төрийн албаны шатлан дэвших тогтолцооны хүрээнд 2 төрийн албан хаагч туслах түшлэлийн албанаас дэс түшмэлийн албан тушаалд дэвшин ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | -Сөбб-ийн багууллага нь нийт 14 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулдаг. Мөн 2022 онд нийт 4 албан хаагчид 498000 төгрөгний албан томилолт, нийт 14 хүний 7879570 төгрөгний үр дүнгийн урамшууллыг олгож ажилласан байна.<br>-Соёлын төв нь 2022 онд нийт 1 албан хаагчид 164000 төгрөгний албан томилолт, нийт 7 албан хаагчийн 2386922 төгрөгний үр дүнгийн урамшуулал олгоод байна. Эрүүл мэндийн төвийн хувьд албан хаагчиддаа ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллаж байгаа бөгөөд 2022 оны хувьд нийт 10 албан хаагчийн 1750000 төгрөгний томилолт, нийт 47 албан хаагчдад 18896287 төгрөгний үр дүнгийн урамшууллыг олгож ажилласан байна. Ерөнхий боловсролын сургууль нь багш ажилчдын нийгмийн баталгааг хангаж ажиллаж байгаа бөгөөд нийт 10 багш ажилчдын 582000 төгрөгний албан томилолт, нийт 51 албан хаагчдын 24308790 улирлын үр дүнгийн урамшууллыг олгож ажлаад байна. | | |
| 31 | 51 | Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай<br>2019.12.25 №472<br>2. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтооход шаардагдах хөрөнгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар **тогтоол** Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 194 дүгээр тогтоолуудын дагуу сумын бүх | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг журмын дагуу цалинжуулан ажиллаж байна. | | |
| 32 | 52 | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2016.01.04 №15<br>1.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллан, татварын нэгдсэн системд холбогдох;<br>1.2. бараа, ажил, үйлчилгээг худалдан авах болон борлуулах тухай бүрт төлбөрийн баримт хэрэглэж, үүнийг хэвшүүлэх;<br>1.3. иргэд, хуулийн этгээдэд төлбөрийн баримт хэрэглэх үйл ажиллагааг хэвшүүлэх талаар нийтэд сурталчлан таниулах. | 2022 оны хагас жилийн байдлаар суманд үйл ажиллагаа явуулж байгаа 7-н Аж Ахуй Нэгж, 5-н Аж Ахуй Эрхлэгчид НӨАТатварын тухай хууль, НӨАТУС-ийн талаар Монгол улсын Сангийн сайдын 2017 оны 12-р сарын 5-ний 347 дугаар тушаалыг үндэслэн ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж ажиллалаа.<br>Төлбөрийн баримтыг хэрхэн албан байгууллагын анхан шатны баримт болгон ашиглах талаах Аж ахуй нэгжүүдэд мэдээлэл хийв. Энэ онд Баян үйлст хайрхан ХХК, Эрч хүч ХХК, Эмийн эргэлтийн сан, Мөнхцагаан толгой ХХК, Гурван тулгат цагаан хайрхан ХХК, Гурван баян загал ХХК, Бүтэн заяа ХХК, Алтан жолоот хүлэг ХХК зэрэг Аж ахуй нэгжүүд нь сумын иргэдэд цахим төлбөрийн баримт болох E-barimt-ыг олгож байна. Засаг даргын тамгын газар, Сум дундын эмнэлэг, ерөнхий боловсролын сургуульд зэрэг албан байгууллагуудад НӨАТ ,НӨАТУС-ийн талаар сургалт хийж Ebarimt-ыг хэрэн бүртгэх, урамшуулалыг хэрхэн тооцох, гар утаснаас 131313 дугаарт бар код үнийн дүнг илгээх, ухаалаг утсанд Аппликейшин суулгах зэрэг мэдээлэлийг хүргэж ажиллалаа. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа 8-н Аж Ахуй Нэгж, НӨАТУС-ийн талаар Монгол улсын Сангийн сайдын 2017 оны 12-р сарын 5-ний 347 дугаар тушаалыг үндэслэн ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж ажиллалаа. | 90% | |
| | | **4.ж Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | |
| 33 | 53 | 2022 оны 2 дугаар сарын 9-ний өдөр 9 дүгээр тэмдэглэл 2022-02-09 Дугаар №99<br>Ү.5.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс шинээр эхлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, орон нутагт эрх нь шилжсэн худалдан авах ажиллагааг яаралтай зохион байгуулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллаж байна. | 100% | |
| 34 | 54 | 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дүгээр тэмдэглэл 2022-03-16 Дугаар №16<br>ХҮ111.13.Орон нутаг дахь боловсролын байгууллагын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг 2022 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн төсвөөс | Ерөнхий боловсролын сургуулийн 80 хүүхдийн ортой дотуур байрны их засвар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу 2022 оны 8 сард хийж гүйцэтгэсэн бөгөөд үүнд 13ш хаалга, | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бүрэн санхүүжүүлж эхэлсэнтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын хэмжээнд төсвийн зохицуулалт хийх арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгов. | 41ш цонхыг сольж, хаалга, цонхны амлагааг хийсэн. | | |
| | | Хэсгийн дундаж 94,5% | | | |
| | | **Тав. Хууль зүй дотоод хэргийн сайд** | | | |
| | | **5.б. Улсын их хурлын тогтоол** | | | |
| 35 | 55 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016.11.03 №51<br>2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай. | Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг жил бүр тооцон төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцон ажилласны үр дүнд авлига, ашиг сонирхлын зөрчил дутагдал илрээгүй байна. | 100% | |
| | | **5.е. Засгийн газрын тогтоол** | | | |
| 36 | 56 | Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2020.03.25 №106<br>1. "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, | Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн дараа аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэгээний дагуу сумын төлөвлөгөө боловсруулан биелэлтийг ханган ажиллаж байна. Архивын ORG-AMS программыг архивын ажилтаны комьютерт суулган захирамжлалын баримт бичиг, явуулсан бичиг өргөдөл гомдолыг тус бүрээр шивэж оруулан архив, бичиг хэргийн эрхлэгчийн гүйтэтгэлийн төлөвлөгөөнд архивын баримтыг цахим тоо хэлбэрт оруулах заалтыг нийтийн ажил үйлчилгээнд зааж биелэлтийг ханган ажилласан. Сумын Засаг дарга 2022 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар боловсон хүчний чиглэлээр нийт 17 захирамж, Засаг даргын Тамгын газрын дарга боловсон хүчний чиглэлээр 21 тушаалыг тус тус шивж оруулаад байна. EPSON маркийн өнгөт принтер, DELL брендийн суурийн компьютерээр хангагдсан. Сумын веб хуудсыг хийлгэх ажилд 750000 төгрөгийг зарцуулж уг хуудсаа байгууллагын ил тод байдал болон архив, албан хэрэг хөтлөлтөнд ашиглаж байна. Байгууллагын бичиг хэргийн ажилтаны албан | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | тушаалын тодорхойлолтонд албан хэрэг хөтлөлтийн талаар болон архивын бичиг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх талаар хүлээх эрх үүргийг тусгаж хөдөлмөрийн гэрээ байгуулан биелэлтийг ханган ажиллаж байна. | | |
| | 57 | 2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч үүрэг болгосугай. | Байгууллага бүр архивын өрөөгөө тохижуулан техник хэрэгсэл ном гарын авлагаар ханган үйл ажиллагаа явуулж байна. Архив бичиг хэргийн эрхлэгч нар байгууллагын архивт ажилтнуудаас баримт бичгийг ХХНЖагсаалт болон хуваарийн дагуу баримтыг хүлээн авч архивын нөхөн бүрдүүлэлтийг жил бүр хийж ажиллаж байна. Суманд тэмдэглэж буй түүхэн ой онцлог үйл явдлын холбогдолтой баримт бичиг болон дүрс бичлэгийг CD дээр буулган файл болон цаасан хэлбэрээр архивт хадгалж байна. | 100% | |
| 37 | 58 | "Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2017.02.01 №46<br>Согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд тус тус үүрэг болгосугай. | Нийгэмд түгээмэл буй архидан согтуурар гэр бүлийн хүчирхийллийн бууруулах чиглэлээр тус сумын ГХУСАЗСЗ даргат болон багийн засаг даргатай хамтран хариуцсан сумандаа өдөр,орой эргүүлийн үүрэг гүйцэтгэнэ ажиллалаа. Үүрэг гүйцэтгэх хугацаанда Зориулалтын бус газар архидан согтуурсан, олон нийтийн гудамж тайлбайд бие зассан ,хог хаясан болон бусдын амгалан тайван байдлыг алдагуулсан гэх нийт 34 хэв журамын зөрчил илрүүлэн хариуцлага хүлээлгэн ажилласанн Цаашидаа гэмт хэрийг таслан зогсоох чиглэлэээр хариуцсан сумандаа эргүүлийн үүргийг эрчимжүүлэн ажиллах болно. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6, 7 дугаар зүйлийг баримтлан Өвөрхангай аймгийн засаг даргын захирамжийн дагуу "Баасан" гарагт архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх тал дээр хяналт тавьж ажилласан. Мөн 21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэхгүй байх тал дээр хяналт тавин ажилласан. Сумын хэмжээнд архинд донтох өвчтэй болсон этгээд өөрийн санаачилгаар эмнэлгийн байгууллагад хандаж сайн дурын үндсэн дээр эмчлүүлэх хүсэлт гаргасан болон архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлүүлсэн хүн байхгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг хоёр иргэнтэй архины хор хөнөөл болон ёс суртахууны талаар сургалт зохион байгуулж дахиж | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ийм зөрчил гаргахгүй байх талаар баталгаа авч ажилласан. Гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл хүлээн авах 102, гэр бүл хүчирхийллийн тусламжийн 107, хүүхдийн тусламжийн 108 дугаарыг иргэд, олон нийтэд сурталчилж, хүнсний дэлгүүрүүдийн мэдээллийн самбарт байршуулж ажилласан. Есөнзүйл сумын цагдаагийн хэсгийн алба хаагчид архидан согтуурдаг хүмүүсийг зөрчлийн тухай хуулиар архидан согтуурсан айл гэрийн амгалан тайван байдлыг алдагдуулсан дуулага мэдээлэл 18 бүргэгдсэн. Үүнээс 17 дуудлага мэдээлэлд арга хэмжээ тооцож ажиллалаа. Зам тээврийн осол гэмтэл байдлаар Есөнзүйл суманд 5 бүртгэгдэж аргар хэмжээг авч ажилласан. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газрын адргын баталсан магестрал замд хяналт шалгалтыг цагийн хуваарийн дагуу тогтмол хийж, Хурд, Гэрэл сумын гарцанд дээр буюу Улсын А/301 магстрал зам 7 хонгийн 3 хугацаанд цагийн менежментийн үүрэг гүйцэтгэж 443 жолоочид 13.269.000 мөнгө бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч, Жолооч нарт хурд тохируулж явах, хамгаалах бүс тогтмол зүүх дээр санамж сэрэмжүүлэг 500 ш боршур тараан ажиллаж байна. Цаашид: Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд тодорхой ажил арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллах болно.Гэр бүлийн хүчэрхийлэл 2 айл бүртгэгдсэн байгаа Одоогоор сумын хамтарсан багтай кэйс нээн ажиллаж байна. | | |
| Хэсгийн дундаж 100% | | | | | |
| **Зургаа. Батлан хамгаалахын сайд** | | | | | |
| **6.е. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 38 | 59 | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2022-03-06 №120<br>2.Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөр төлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 2022 оны жилийн эцсийн байдлаар 19 иргэний мөнгөн төлбөрийн тооцоог хийлгэн төлбөр тооцоог барагдуулан ажиллаж байна. | 100% | |
| 39 | 60 | Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай"<br>2021.07.28 №220<br>2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Тус сумаас цэргийн дүйцүүлэх албанд 2022 оны хагас жилийн байдлаар цэргийн дүйцүүлэх албыг хааж буй иргэн байхгүй байна. 2022 оны хагас жилийн байдлаар 19 иргэн мөнгөн төлбөрийн тооцоог хийн ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хэсгийн дундаж 100% | | | | | |
| **Долоо. Барилга, хот байгуулалтын сайд** | | | | | |
| | **7.е. Засгийн газрын тогтоол** | | | | |
| 40 | 61 | Журам шинэчлэн батлах тухай.<br>2019.08.14 №325<br>1. “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.<br>2. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг бүрэн хаягжуулах, улсын хэмжээний хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан дараахь арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:<br>д/ харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлах гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах болон хаягийн тэмдэг, тэмдэглэгээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Тус тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2014 онд хаягжуулалтын тогтоол батлуулж зураглалыг гарган Засаг хаягийг 2018 оны 1-р сарын 8-ны Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын даргын Тамгын газрын төсвөөс 200000 төгрөгөөр Мөнхбулаг 2-р багийн 175 хашааны хаалганы дугаарыг өөрсдийн хүчээр хийж хаягжуулсан. 2015-2018 оны хооронд шинээр үүссэн гудамж хорооны тогтоолоор нэмэлт оруулж батлуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын хаягийн мэдээллийн санд оруулан ажилласан.<br>2022 оны жилийн эцсийн байдлаар шинээр гудамж талбай, зам, үл хөдлөх эд хөрөнгө бүртгэгдээгүй учир хаягийн мэдээллийн санд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна. | 100% | |
| 41 | 62 | Журам шинэчлэн батлаж тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай<br>2016.01.04 №10<br>Журам шинэчлэн батлаж тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Тус батлагдсан журмын дагуу 2022 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд 3 нэгж талбарыг дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр тусгасаны дагуу сумын засаг даргын 2022 оны а/42 тоот захирамжаар зарлан mle.mn цахимаар явуулж 3 нэгж талбарын ялагч тодроогүй. Дуудлага худалдааг дахин зарлаад байна. | 100% | |
| Хэсгийн дундаж 100% | | | | | |
| **Найм. Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд** | | | | | |
| **8.е. Монгол Улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 42 | 63 | Журам батлах тухай 2022-11-02 №392<br>“Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай | Улсын хэмжээнд 4 жил тутам хийдэг “ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН” тооллогыг сумын хэмжээнд 19 дэсийн 114 булш хиргисүүр тоолж, бүртгэж “Гэрээт өв хамгаалагч” нартай уулзаж соёлын өвийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам" 5.1.Үндэсний жагсаалтад бүртгэсэн соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах ажлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүх шатны Засаг дарга, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулна. | эрх зүйн зөвлөгөө өгч, санаа бодлоо солилцон тулгарч буй асуудлыг ярилцлаа.Аймгийн хамгаалалтанд байдаг "Наран толгойн дурсгал", "Буурлын хүн чулуун хөшөө"Өвөрхангайаймгийн Соёл урлагийн газраас ирсэн баг бүрэлдэхүүнтэй Бүжгийн багш Ж.Батсайхан, Орон нутаг судлах танхимын ажилтан Н.Анузаяа, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхбаяр нар хамтран явж бүртгэл тооллогын ажлыг хийж гүйцэтгэсэн.Сумын хамгаалалтанд бүртгэлтэй булш хиргисүүрийн тооллогыг Т.Нарангэрэл ахлагчтай 6 хүний бүрэлдэхүүнтэй нийт 7 удаагийн явалтаар 460 км орчим зам туулан ЗДТГ-аас 110 литр бензин буюу 291500 төгрөг, Өвөрхангай Соёл урлагийн газраас 60 литр буюу 159000 төгрөг , Замын хүнсэнд 291000 төгрөгийг зарцуулан тооллогын ажлыг зохион байгууллаа."Хөшөөн дэнжийн хөшөө" , "Жонон вангийн хэрэм" дурсгалт газрын хаяг, пайзыг 100000 төгрөгөөр цементлэн сэргээн засвар хийж ажиллалаа. | | |
| 43 | 64 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 №314 2.Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дунд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Ардын урлаг болох дуу, бүжгийг хүүхдүүд болон насанд хүрэгчдэд дугуйлангийн багш нар идэвхтэй хичээллэж хүүхдийн тоог нэмэгдүүлж ажиллаж байна. Бага,дунд, ахлах анги нийлсэн 30 хүүхэд бүжгийн дугуйланд хичээллэдэг.Монгол ардын бүжиг, Чөлөөт бүжиг, Бий биелгээ гэсэн 3 төрлийн бүжгийг тогтмол цагийн хуваарийн дагуу зааж сурган дугуйлангийнхаа үйл ажиллагааг явуулдаг. Соёлын төвийн эрхлэгч сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан 2022 оны урамшуулал болох 2,500,000 төгрөгийг олгож ажиллаад байна. Соёлын төвийн дарга Т.Нарангэрэл уртын дууны дугуйланг тогтмол хичээллүүлж 7 хоногийн мягмар, пүрэв гаригт 2 групп нийт 8 цагийн хичээл орж байна. Дугуйлангийн тогтмол суралцагч 40 сурагчид уртын дууны анхан шатны ойлголтуудыг өгч "УУХАЙ" дасгалаас эхлэн амьсгааны дасгалууд, өнгө тогтоох дасгалууд, үг хэллэг зөв тод дуудах | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | дасгалууд, "Хөөрхөн халиун", "Өнчин цагаан ботго", "Зээргэнэтийн шил", "Оломгүй далай", "Эрхэм төр" "Саруул талбай" зэрэг уртын дуу, "намрын хонгор салхи", "Баатар цогтын нагац", "Цоохор морь", "Эхийн ач" зэрэг ардын дуу, "Боодогтой сэвгэр", "Борооны үүл" дууг 2 хоолойгоор, "Багачуудын ордон", "Гэгээн өглөө сайн байна уу", "Сайн байна уу шинэ он оо" зэрэг хүүхдийн дууг заасан. Соёлын яамнаас "Бүтээлч сар" аян зарласантай холбоотойгоор иргэдэд олон талт үйл ажиллагаа зохион байгуулан бусад байгууллагын арга хэмжээнүүдэд байраар хангаж үзвэр үйлчилгээг тогтмол явуулж иргэдийг сэтгэл ханамж өндөр гаргадаг болсон. | | |
| 44 | 65 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар №7<br>5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br>5.1.эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;<br>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;<br>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; | Улс орон даяар зохион байгуулсан Төрийн албан хаагчдын "Монголбичгийн түвшин тогтоох" судалгаанд бүрэн хамруулан ажилласан. 2025 онд албан бичгийг хос бичгээр хөтлөх болсонтой холбоотойгоор бэлтгэл ажлыг хангахын тулд төрийн албан хаагчдыг анхан, дунд шатны сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. "Монгол бичиг үндэсний хөтөлбөр-3"-ыг сурталчилан цахим хэлбэрээр бэлтгэн ажилласан. Цар тахалтай холбоотойгоор танхимын сургалт явуулах боломжгүй тул "Монгол бичгээ дээдлэгч сум" уриан дор монгол бичгийн цахим хичээлийг группэд байршуулсан. Мөн 12-р ангийн сурагчид Chime аппликейшныг ашиглан Өвөрхангай Есөнзүйл "Монгол бичгээ дээдлэгч сум " группэд дурын сэдвээр эх бэлтгэн оруулж байна. ЕБС-ийн 2 давхрыг үндэсний бичгийн орчинг бүрдүүлэх зорилгоор НУЗАН-ийнхэн Монгол хүүхдийн эрхэмлэх 9 зүйл, НУЗАН-ийн уриаг үндэсний бичгээр бичин байршуулсан. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | Сургуулийн удирдлагын багийнхан “Хүндэт самбар”-ын орчинд багшийн тухай 4 мөртийг үндэсний бичгээр бичсэн. Нийт 110 ТАХ-ыг Монголбичгийн уншлагын ном, Хичээнгүй бичгийн номоор ханган бие даан сурах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. | | |
| 45 | 66 | Үдийн хоолны норматив тогтоох тухай 2021-08-11 Дугаар №237<br>4.Энэ тогтоолын 1, 3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд 2021 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг 2021 онд батлагдсан төсвийн багцдаа зохицуулалт хийж, 2022 оноос улсын болон орон нутгийн төсвийн төсөлд зохих журмын дагуу тусган хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | 2021-2022 оны хичээлийн жилээс бага ангийн сурагчдын үдийн цайг журам заавар, чиглэлийн дагуу үдийн хоол болгон хэрэгжүүлж байгаа бөгөөд 7 хоног тутамд хоолны цэсийг өөрчлөн баталгаажуулж цэсийн дагуу халуун хоол ундаар үйлчилж байна. Өдөр бүрийн үдийн хоолны явц, ирц, хоолны цэс, зургийн хамт цахим системд шивж оруулж хэвшээд байна. . | 100% | |
| 46 | 67 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2021.02.24 №47<br>3.Эрсдэлгүй ногоон бүсэд танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн цэцэрлг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг зохих журам, зааврын дагуу ариутгаж халдавргүйжүүлэхэд нэн шаардлагатай ариутгалын бодим, багаж, хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 2021-2022 оны хичээлийн жилд хичээл сургалтын үйл ажиллагаа танхимаар бүрэн хичээллэж эхэлсэн бөгөөд сурагчдын хоёрдугаар улирлын хичээл 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр эхэлсэн. Үүнтэй холбогдуулан сургуулийн бүх объектод их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийж сурагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан. Мөн сумын хэмжээнд салхин цэцэг өвчин гарсантай холбогдуулан ариутгал халдваргүйтгэлийг сумын эрүүл мэндийн байгуулагатай хамтран хийхийн зэрэгцээ өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тогтмол хийж хэвшсэн. | 100% | |
| 47 | 68 | Төлөвлөгөө батлах тухай 2021-01-20 Дугаар №18<br>2. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.<br>3. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн жил бүрийн | Ерөнхий боловсролын сургуульд хүүхдийн насны онцлогт тохирсон эрүүл, аюулгүй хоол хүнсний үйлчилгээг үзүүлэх зорилгоор БСШУ-ны яамнаас ШУТИС-тай хамтран зохион байгуулсан 2 дугаар шатны сургалтад 4 тогооч, нярав, эмч, захирал, бага ангийн сургалтын менежер хамрагдсан. Бага ангийн үдийн цай бүрэн үдийн хоол болсон. Ирэх хичээлийн жилээс дунд | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | ангийн сурагчид хоол цайгаар үйлчлэхтэй холбогдуулан 320 хүүхдийн суудалтай хичээлийн байрны гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмжийг авч байршуулсан. | | |
| 48 | 69 | Үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2020.03.18 №96<br>1. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн дэмжлэгээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | Үндэсний бичгийн хичээлээр монгол бичгийн аппликейшин ашиглан хичээл сургалтын үйл ажиллагааг сонирхолтой хэлбэрээр зохион явуулж байна. Жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Эх хэлний өдөрлөг”-өөр зохион явуулсан үйл ажиллагаанаас шалгарсан сурагчдыг дараагийн шатны уралдаанд амжилттай оролцууллаа. “Түгээгч-Тээгч”-үндэсний бичгийн улсын уралдааны нэгдүгээр шатыг сургуульдаа зохион байгуулж, хоёрдугаар шатанд 6-12-р ангийн 210 суралцагчийг амжилттай бэлтгэн оролцууллаа. Тус сургуулийн монгол хэл, уран зохиолын 3 багш төрийн албан хаагчдад 2022 оны 10 сараас эхлэн нэг сарын хугацаанд монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтуудыг хуваарийн дагуу зохион байгуулж ажиллалаа. | 100% | |
| 49 | 70 | Коронавируст халдвар (covid-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2020.04.15 №139<br>2. Сургалтын үйл ажиллагааг зогсоосон хугацаанд боловсролын байгууллагын гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түлш халаалт зэрэг байр ашиглалттай холбоотой зардлыг хэмнэх зорилгоор шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | ЕБС<br>Аймгийн Засаг даргын захирамжаар байр ашиглахтай холбоотой халаалтыг 05 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоосон болно. Сургалтын үйл ажиллагаа түр зогсоосонтой холбоотой гэрэл цахилгаан цэвэр бохир усны зардал хэмнэгдсэн байна. Сурлагын хоцрогдлыг арилгах төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу танхим болон цахим сургалтыг хослуулан зохион байгуулж ирсэн бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилээс бүгд танхимаар хичээллэж байна. энэ хугацаанд мэргэжлийн багш нар цахим хичээл боловсруулж medle.mn сайтад | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байршуулахын сацуу уг сайтад тавигдсан хичээлүүдээс авч сургалтандаа ашиглаж байна. | | |
| 50 | 71 | Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай /Үдийн цай/ 2006.08.16 №19 Үдийн цай" хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд, үдийн цайнд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, орчны ариун цэврийн талаар тогтмол хяналт тавих ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүхэд тус тус даалгасугай | 2022 онд ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 9 бүлгийн нийт 199 суралцагч үдийн хоол үйлчилгээнд хамрагдсан бөгөөд нийт 20 сая төгрөгийг зарцуулсан байна. Бага ангийн сурагчдын үдийн хоолны тогооч, багш, нярав, нягтлан үе шаттай сургалтуудад хамрагдсан бөгөөд боловсролын нэгдсэн мэдээллийн системд тухайн өдрийн хоолны цэс, илчлэг калори, хийсэн хоол, ирц бүртгэлийг тогтмол оруулж тайлан мэдээг гаргаж байна. Сургуулийн дотоод хяналтын нэгж, жижүүр багш, үдийн хоолны ажиллагаатай танилцан эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм хэрхэн баримтлан ажиллаж буйд үнэлгээ дүгнэлт өгч, гарсан зөрчлийг цаг тухай бүр залруулан заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Анги удирдсан багш нар биеийн тамирын багш нартай хамтран улирал бүр сурагчдын биеийн жингийн индексийг гаргаж хэвшсэн. Сурагчдын бие бялдрын хөгжил болон өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдын үдийн хоолонд халуун аарц, болон чацарганы шүүс сүүн бүтээгдэхүүйн бүтээгдэхүүн зэргээр байнга үйлчлэн долоо хоногийн 5 өдөр халуун хоол цай өгч байна. Мөн үдийн хоол хөтөлбөрт бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх тендер зарласны дагуу сумын Баян-Үйлст ХХК, Алтанжолоот хүлэг ХХК-ууд шалгаран гэрээ байгуулан 7-14 хоног тутамд хүнсний бүтээгдэхүүний баталгааны бичиг, шинжилгээ, гарал үүслийн бичигтэй бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байна. | 100% | |
| Хэсгийн дундаж 97,7% | | | | | |
| | **Ес . Хүнс , хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд** | | | | |
| | **9.е. Монгол Улсын Засгийн газрын тогтоол** | | | | |
| 51 | 72 | Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-03-16 Дугаар №118 5.Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор иргэдийн төмс, хүнсний ногоо тариалах идэвх, санаачилгыг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх болон хүнсний ногооны тээвэрлэлт, хадгалалт, худалдааны сүлжээг хөгжүүлэх, хөдөөгийн хүн | Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж малын тэжээл, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Сумын хэмжээнд нийт 200 шуудай тэжээлийн үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан ав сумын хэмжээнд нийт 110 өрхөд тараан өгч ажилласан. 5 тн ногоон тэжээлийг хүрээн аваад байна. Мөн 400кг төмсний үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан авч 4 багийн иргэдэд тараан өгч ажилласан. Мөн аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | амын хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 40кг төл сонгины үр, сормис, байцаа, лууван, гар манжин, хүрэн манжингийн үрийн захиалга хүргүүлж үрийг авчран өрхүүдэд тараан тариалан дэмжих сангаас усжуулалтын системийг аван ажиллаад байна. | | |
| 52 | 73 | Журам батлах тухай 2022-03-02 Дугаар №92<br>2. "Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>3. Удам зүйн үнэт чанарын хувьд өвөрмөц, хязгаарлагдмал нөөц, тархалт бүхий мал, амьтныг хамгаалах, зохистой үржүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 2022 онд Сумын хэмжээнд 3-н өрхөд Хуц 343 Ухна 303 хээлтүүлэгчийг суурлан малын үзлэг ангилалтыг үе шаттайгаар явуулж, ээмэгжүүлж, шинжилгээнд хамруулах ажлыг хувийн мал эмнэлэгийн байгууллагатай хамтран зохион байгуулан ээмэгжүүлсэн хээлтүүлэгч малын бүртгэл мэдээллийн санд оруулан ажиллалаа. Мөн өсвөр хээлтүүлэгч 50 хурга 30 ишиг шинээр үржилд ашиглахаар зохион байгуулан ажиллалаа. 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хээлтүүлэгч малыг бүрэн таарч 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс үржилд ашиглах ажлыг зохион байгуулан ажилласан. Малын индекжүүлсэн даатгал 60 өрхийн 12457 өрхийн малыг хамруулан ажиллалаа | 70% | |
| 53 | 74 | Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай 2022-02-16 Дугаар №74<br>3. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 5- 7 дугаар сард багтаан зохион байгуулахаар тогтоосугай.<br>4. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг улсын хэмжээнд Зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.<br>5. Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Хөдөө аж ахуйн ээлжит тооллого зохион байгуулж байгаатай хологдуулан сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/83 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Сумын хэмжээнд 2 тоологч, 1 шалгагч, 1 жолооч ажиллах бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт сургалтанд хамрагдсан. Статистик хариуцсан мэргэжилтэн 2 ширхэг ТАВ төхөөрөмжийг дээд шатны байгууллагатай гэрээ байгуулан авч ирсэн бөгөөд 2 тоологч тоологод гарах бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллаж байна. | 90% | |
| 54 | 75 | Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-02-23 Дугаар №81<br>3."Хоршооны хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд | Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 2022 оны 1 хоршоо, 3 Аж ахуй нэгж, 18-н иргэний төсөл "Төсөл сонгон шалгаруулах хороогоор" хэлэлцэгдсэнээс 1 хоршоо, 3 Аж ахуй нэгж, 10 иргэний төсөл тэнцэж үнэлгээний хороонд хүргүүлж ажиллаа. Хоршоо хөгжүүлэх | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Жижиг, дунд үйлдвэрийн газар (Я.Эрдэнэсайхан)-т тус тус үүрэг болгосугай. | сангаас 180 сая төгрөгийн санхүүжилтээр сумын тэргүүлэх чиглэлийн хүрээнд<br>- Эсгий үйлдвэрлэл : 1 Хоршоо<br>- Авто машин засвар үйлчилгээ: 1 ААН Хоршоо-1<br>- Бууз, банш, хэрчсэн гурилын цех :1 ААН ААН-3<br>- Зочид буудал, цайны газар: 1 ААН Иргэн-10<br>- Сүү, Цагаан идээ боловсруулах : 4 иргэн<br>- Мах, дайвар бүтээгдэхүүн: 1 иргэн<br>- Гутал, монгол гутал үйлдвэрлэл: 2 иргэн<br>- Хэрчсэн гурил үйлдвэрлэл: 1 иргэн<br>- Оёдол: 1 иргэн<br>- Нэхмэл шүр: 1 иргэн<br>Төслийг сонгон шалгаруулж 1 хоршоо, 3 ААН, 10 иргэний төслийг дэмжин сум орон нутагтаа ажлын байр бий болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэн амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлж ажиллалаа. | | |
| 55 | 76 | Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай<br>2021.07.28 №221<br>2.1. Улсын хэмжээнд 2021-2022 онд өвөлжих болон хэрэгцээлэх малын тоог малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тохируулан аймаг, нийслэл, сум, дүүргээр нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах малын тоог тодорхойлж, экспортлох төлөвлөгөө, хуваарь гарган, энэ чиглэлээр хүнсний болон хөнгөн үйлдвэрүүдтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Сумын хэмжээнд нийт 79240 ингэ 76, гүү 4517, үнээ 2879, эм хонь 45002, эм ямаа 26796 төллөхөөс ботго 60, унага 3821 тугал 2472, хурга 44955, ишиг 25014 нийт 76322 төллөж сумын хэмжээнд 95 хувийн мал төллөсөн байна | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 56 | 77 | Журам батлах тухай<br>2020.03.25 №113<br>1. “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг хавсралтаар батлсугай.<br>2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | 2022 оныг Хоршооны хөгжлийг дэмжих жил болгон энэ хүрээнд “Харилцан туслалцаж хамтдаа хөгжье” уриатай Өвөрхангай Аймгийн хоршоологчдийн зөвөлгөөнд оролцон сургалтаас олж мэдсэн мэдээ мэдээлллийг орон нутагтаа суртчилан ажиллаж байна. Сум хөгжүүлэх санг Хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчилж үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан “Сум хөгжүүлэх сан”-ийн программын нэр Төрийн сан дахь сум хөгжүүлэх сангийн дансны нэрийг Хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчлөөд байна. Сангаас зээл авсан иргэдэд дансны нэрийг зөв бичихийг анхааруулан ажиллаж байна.Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 2022 оны 2-р улирлын байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 16.707.685.00 зээлдэгчийн тоо 37 иргэн аж ахуйн нэгж байгаагаас 249,291,851,25 зээлийн үлдэгдэлтэй байна. Цаашид хугацаа хэтрэлтийн 34,4 хувийг бууруулж хугацаа хэтэрсэн зээлүүдийг эргэн төлүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллана. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар баталсан “ **Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам** ”-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээж авах үйл ажиллагааны зарыг орон нутгийн мэдээллийн сайтуудад байршуулан 3 аж ахуйн нэгж, 1 хоршоо, 8 иргэнд нийт 170,300,000 төгрөгний зээлийг олгоод байна. | 100% | |
| 57 | 78 | Үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2020.01.29 №34<br>1. “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор батлсугай<br>3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвт багтааж хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Монгол малчин үндэсний хөтөлбөрийн хүрээнд: Сумын хэмжээнд 500 хонь 250 ямааг ээмэгжүүлэн малын бүртгэлийн программ оруулан ажиллалаа. Мөн 2000 бог малыг ээмэгжүүлэх ажлыг 2022 оны 08 дугаар сарын 10-20 дотор хийж гйүцэтгэх төлөвлөгөөтэй ажиллаж баина | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 58 | 79 | Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай 2019.05.01 №185<br>4. 2019 оны бэлчээр хамгааллын арга хэмжээг нийтийг хамарсан ажил болгон зохион байгуулах, цаашид жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарлаж, мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | 2021 оны ИТХ-ын төлөөлөгчийн 2021 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 09 тоот тогтоолоор Зүүн хайрхан, Дөлгөөн хайрхан, өвөлжөө, хаваржааны газрыг 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл чөлөөлүүлэх шийдвэр гарсан. Уг тогтоолын дагуу бэлчээрийг чөлөөлүүлэх ажлыг 85%-тай зохион байгуулж ажиллалаа. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтан их хэмжээгээр тархсан Тахилга, Мөнхбулаг, Хайрхан, Эрээний багуудад 8000 га-д 2022 оны 05 дугаар сарын 05-аас 2022 оны 05 дугаар сарын 08 –ний өдөр хүртэл 3 хоног микробиологийн аргаар үлийн цагаан оготны устгалын ажлыг хийж гүйцэтгээд байна. | 100% | |
| 59 | 80 | Үндэсний хөтөлбөр батлах тухай / Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр/ 2019.04.17 №156<br>3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улс болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 2022 оны 1 хоршоо, 3 Аж ахуй нэгж, 18-н иргэний төсөл “Төсөл сонгон шалгаруулах хороогоор” хэлэлцэгдсэнээс 1 хоршоо, 3 Аж ахуй нэгж, 10 иргэний төсөл тэнцэж үнэлгээний хороонд хүргүүлж ажиллаа. Хоршоо хөгжүүлэх сангаас 180 сая төгрөгийн санхүүжилтээр сумын тэргүүлэх чиглэлийн хүрээнд<br>- Эсгий үйлдвэрлэл : 1 Хоршоо<br>- Авто машин засвар үйлчилгээ: 1 ААН Хоршоо-1<br>- Бууз, банш, хэрчсэн гурилын цех :1 ААН ААН-3<br>- Зочид буудал, цайны газар: 1 ААН Иргэн-10<br>- Сүү, Цагаан идээ боловсруулах : 4 иргэн<br>- Мах, дайвар бүтээгдэхүүн: 1 иргэн<br>- Гутал, монгол гутал үйлдвэрлэл: 2 иргэн<br>- Хэрчсэн гурил үйлдвэрлэл: 1 иргэн<br>- Оёдол: 1 иргэн<br>- Нэхмэл шүр: 1 иргэн | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Төслийг сонгон шалгаруулж 1 хоршоо, 3 ААН, 10 иргэний төслийг дэмжин сум орон нутагтаа ажлын байр бий болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэн амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлж ажиллалаа. | | |
| 60 | 81 | "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөр батлах тухай 2017.09.22 №278<br>3.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч П.Сэргэлэн, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж малын тэжээл, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсанаас атаршсан тариалангийн 6 га талбайг иргэд, аж ахуй нэгжид сумын тусгай хэрэгцээнд авч гэрээгээр олгож эзэмшүүлсэн. Сумын хэмжээнд нийт 200 шуудай тэжээлийн үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан ав сумын хэмжээнд нийт 110 өрхөд тараан өгч ажилласан. 5 тн ногоон тэжээлийг хүрээн аваад байна. Мөн 400кг төмсний үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан авч 4 багийн иргэдэд тараан өгч ажилласан. Мөн аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар 40кг төл сонгины үр, сормис, байцаа, лууван, гар манжин, хүрэн манжингийн үрийн захиалга хүргүүлж үрийг авчран өрхүүдэд тараан тариалан дэмжих сангаас усжуулалтын системийг аван ажиллаад байна. | 100% | |
| **9.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 61 | 82 | 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 49 дүгээр тэмдэглэл 2021-08-31 Дугаар 2021_49<br>Х111.5.2.Төрийн болон орон нутгийн музейн харуул хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, зааварчилгааг хамтран баталж мөрдүүлэх, харуул хамгаалалтын ажилтны ур чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Соёлын өвийн гэрээт харуулуудаас хагас жилийн тайланг бичгээр болон фото зураг хэлбэрээр авч ажиллаа. Шинээр бүртгэсэн соёлын өв болон өв хамгаалагч нар байхгүй. Улсын тооллогыг хийж гүйцэтгэх бэлтгэл ажлыг хийж явах газрын маршрутыг гарган ажиллаа. Орон нутаг судлах танхим буюу "Бурхан бумбын орон" уран зургийн галарейгаар үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн тоо хагас жилийн байдлаар 300 гаруй хүнд үйлчилсэн байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | X111.5.4.Харьяалах нутаг дэвсгэр дэх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | |
| Хэсгийн дундаж 94,5% | | | | | |
| **Арав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** | | | | | |
| **10.е. Монгол Улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 62 | 83 | / "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын дүрэм"/ Дүрэм шинэчлэн батлах тухай 2021.06.23 №173 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, санхүүгийн зохих дэмжлэгийг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн ГБХЗГ, БОЭТ, БСУГ-ын хамтарсан баг хүүхэд хамгаалал болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах нөхцөл боломж, эрүүл мэнд, эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт мэдээлэл хийх ажлаар тус сургуульд ажиллаж 5 сурагчийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр болсны сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч 2022 оны 05 дугаар сард үзлэгт хамруулсан бөгөөд нэг сурагч хөгжлийн бэрхшээлтэй гэж тогтоогдсон. 2022 оны эхний хагас жилд тус сургуульд 4 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаагаас 2 сурагч нь ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна. 2022 онд Аймгийн комиссоор 4 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлуулахаар явуулж 1 хүүхдийг шинээр асаргааны тэтгэмжид хамруулж, 3 хүүхдийн асаргааны хугацааг сунгуулав. | 100% | |
| 63 | 84 | "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл" батлах тухай 2021.03.10 №58 3.Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих байгууллалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай. | 2022 онд Залуучуудын оролцоо төсөлд хамрагдахаар 4 иргэн бүртгүүлсэн 2 залуу ярилцлаганд орж тэнцсэн боловч эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамрагдаж чадахгүйн улмаас төсөлд яваагүй. | 100% | |
| 64 | 85 | Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2019.03.21 №111 2. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг | 2022 онд Сум дундын эмнэлэг1, ЕБС- 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байгаа тул төлбөр гараагүй болно. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Хамгаалалтын хувцас хэрэгсэлгүй 2 хүүхдийг уралдааны замд гаргалгүй буцаасан. | | |
| 66 | 87 | Дүрэм батлах тухай<br>2016.12.21 №200<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай. | 2022 онд Аймгийн комиссоор 4 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлуулахаар явуулж 1 хүүхдийг шинээр асаргааны тэтгэмжид хамруулж, 3 хүүхдийн асаргааны хугацааг сунгуулав. | 100% | |
| 67 | 88 | Журам батлах тухай<br>2017.01.02 №31<br>Засгийн газрын 2017 оны 31 дүгээр тогтоолын хавсралт<br>Хоёр. Насны хишиг авах ахмад настны хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх | 2022 онд насны хишигт 1-р сард 147 ахмад настан хамрагдаж 13900,0 мян/төг олгосон. 7-р сард олгогдох насны хишгийн олголтыг хянаж 8 ахмад нэмэгдэж 4 ахмад настан хасагдаж 151 ахмад насны хишигт хамрагдахаар байна.. | 100% | |
| 68 | 89 | Журам батлах тухай<br>2017.12.13 №340<br>2. Жирэмсэн эхийн тэтгэмжийн хэмжээг сард 40.000 (дөчин мянган) төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг сард 50.000 (тавин мянган) төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 1.000.000 (нэг сая) төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 3.000.000 (гурван сая) төгрөг байхаар тус тус тогтоосугай. | 2022 онд Жирэмсэн эхийн тэтгэмж авах эрх үүссэн 28 эхэд жирэмсний тэтгэмж 40000 төгрөгийг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж авах 162 эхэд / цалинтай ээж хөтөлбөрт/ 50000 төгрөгийг, гурав болон түүнээс дээш хүүхэд төрүүлсэн өрх толгойлсон 6 эх-д 420000 төгрөгийн тэтгэмжийг тус тус олгоод байна | 100% | |
| 69 | 90 | Дүрэм батлах тухай<br>2018.01.03 №4<br>1. Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрмийг 1 дүгээр хавсралт, орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. | Засаг даргын 2021 оны 05 дугаарр сарын 03-ний өдрийн А/71 дугаартай захирамжаар ажлын хэсгийг батлан, салбар зөвлөлийн дүрмийг ажлын хэсэгт танилцуулан жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засаг даргын 2022 оны 03 сарын 23-ны өдрийн А/38 дугаартай захирамжаар Залуучуудын хөгжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулж жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Залуучууд хөгжлийн зөвлөлийг 21 гишүүнтэй, дөрвөн багийн дэргэдэх залуучууд | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай. | | | |
| 65 | 86 | Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2019.01.03 №57<br>1. Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.<br>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Сумын 90 жилийн ойн баяр наадмаар Хурдан морь унаач хүүхдийг уралдаанд гаргахдаа эцэг эх, асран хамгаалагчийн бичгээр гаргасан зөвшөөрөл байх, хамгаалалтын хувцыг стандартын дагуу бүрэн гүйцэт, зөв өмсөх, хурдан морины уралдаанд уралдах морийг долоогоос дээш насны хүүхдээр унуулах, уралдаанч хүүхэд бүрийг нэг жилийн ослын даатгалд хамруулсан байх, морины үсэргээ, сунгаа, уралдааны үед хүүхдийн амь нас, аюулгүй байдалд уяачид онцгой анхаарч хүүхдийг өлсгөх дааруулах, уралдааны үр дүнгээс шалтгаалан хүүхдэд дарамт хүчирхийлэл үйлдэхгүй, хүүхэдтэй зүй бус харьцахгүй байхыг анхааруулсан мэдээлэл, зөвлөмж, шторк, контентийг /Сумын нэгдсэн зар, Засаг даргын Тамгын газар, Төрийн албан хаагчийн нэгдсэн грүпп, Өндөр гэзгээний хурд уяачдын грүпп, зэрэг цахим хуудсанд 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс баяр наадмын үйл ажиллагаа дуусах хүртэл өдөр бүр санамжуудийг байршуулан малчид хөдөлмөрчид, уяачид, ард иргэдэд анхааруулага мэдээ мэдээллийг цаг тухайд нь тогтмол өгч ажиллалаа.<br>Сумын 90 жилийн ой, баяр наадмын өдрүүдээр<br>• Азарга-31<br>• Ихнас-91,<br>• Хязаалан-42,<br>• Шүдлэн-46,<br>• Соёлон-60,<br>• Даага-39<br>нийт 6 насны 309 хурдан морь уралдаж, Хурдан морьноос унасан Азарга-2, соёлон-3, даага-4 унаж эрүүл мэндийн төвийн баг бүрэлдэхүүн шуурхай тусламж үзүүлэн ажиллаж унасан хүүхдүүдийн бэртлийн зэрэг хөнхөн оноштой амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирсан тохиолдол гараагүй. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хөгжлийн зөвлөлийг 11 гишүүнтэй байгуулан арга зүйгээр хангаж ажиллаад байна. | | |
| Хэсгийн дундаж 100% | | | | | |
| **Арван нэг. Эрүүл мэндийн сайд** | | | | | |
| **1.е. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 70 | 91 | Дүрэм шинэчлэн батлах тухай 2021.03.17 №67<br>2.“Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт, хэрэгжүүлж ажыг Нийгмийн даатгалын ерөнхий газар Д.Зоригт, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.<br>4.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэж, даатгуулагч иргэнийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн сайл С.Энхболд, аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдалтын тахир дутуугийн тэтгэвэр авдаг иргэний мэдээллийг эмнэлэг тулган хянаж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр иргэдэд хандсан сургалт, сурталчилгаа, гэрийн эргэлт болон багийн эмч нар судалгаа гаргаж сард нэг удаа үзлэг шинжилгээг хийж их эмч нар хоёр сардаа нэг удаа хянан гарын авлага, зөвлөмж шинээр боловсруулан танилцуулж, Мөн багийн эмч, багийн дарга нартай хамтран ажилж байна. Эрүүл мэндийн төв нь хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийг хэвтэн эмчлүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангах, таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зэрэг ажлууд хийгдсэн байна. Хөдөлмөрийн чадвараа адлсан иргэдтэй эрүүл мэндийн төвийн багийн эмч нар мөн нийгмийн эрүүл мэндийн ажилтан нар шаардлагатай иргэдийн гэрт нь очиж үзлэг хийж, мэлээлэл сургалт сурталчилгаагаар хангаад хэвшээд байна. | 100% | |
| 71 | 92 | Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги батлах тухай 2015.08. 31 №353<br>3. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайд, аймаг, | Цар тахлын улмаас иргэдэд чиглэсэн сургалт хийгдээгүй. Эмнэлгийн 22 эмч мэргэжилтнүүдэд “Давсны зөв хэрэглээ”, “Давсыг юугаар орлуулж болох вэ?” сэдвээр дотоодын сургалт зохион байгуулж , сургалтын өмнө ба дараа хүний хоногт хэрэглэх давсны хэмжээ хэд байх талаар мэдэг сорих асуултанд сургалтын өмнө 43,7, сургалтын дараа 80, 7 болж өссөн байлаа.Хүнсний худалдаа үйлчилгээ явуулдаг болон , гал тогоо бүхий 12 үйлчилгээний байгууллагад 40 ширхэг зөвлөмж бэлтгэн хүргүүлж, үйлчилгээний байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан. | 90% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | | | |
| 72 | 93 | Үндэсний хөтөлбөр батлах тухай /Орчны эрүүл мэнд/ 2017.08.09 №225<br>3.Хөтөлбөрийн хэрэгжилтийг салбар, орон нутгийн түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.<br>4.Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Ундны усны зөв хэрэглээ, зөөвөрлөлт, хадгалалт сэдвээр сургалт хийж 143 хүнийг хамруулж гарын үсэг фото зургаар баримжуулсан. Мөн ОО, муу усны цооногийн тоог нэмэгдүүлэх, стандартын нүхэн жорлонгийн талаар мэдээлэл хийснээр шинээр 12 ОО шинээр баригдснаас хөдөөд 1, Стандартад ойртуулсан нь 1 байв. Улиралын байдалд тохируулан хавар, зуны цагт, гэдэсний халдвар гарах эрсдэлийг бууруулах зорилгоор гэдэсний халдвараас хэрхэн сэргийлэх талаар 211 хүнд мэдээлэл хийж, сумын төвийн 200 айл өрх, 11 төрийн болон төрийн бус байгууллагын ОО, муу усны цооногийг ариутгаж 10% хлорын шохойн сүүн уусмалаар халваргүйтгэсэн. Хүйтэн сэрүүний улирал эхлэх үед томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх томуугийн 100 хүн тун вакциныг эмнэлгийн ажилчид, жирэмсэн эхчүүд, архаг хууч өвчтэй хүмүүст хийсэн. Эмнэлгийн хог хаягдлыг цуглуулах уут сав, аюулгүй хайрцагыг эмийн тендэрт захиалан хангалттай авч, хар уутанд ердийн, шар уутанд халдвартай хог хаягдлыг цуглуулж, аюулгүй хайрцаганд тариур, ампул зэргийг хийж нээсэн он сар өдрийг тодорхой бичиж, 3/2 хэмжээнд хүрмэгц шатааж устгаж байна. Жилд дунджаар аюулгүй хайрцаг 250 ширхэгийг хэрэглэж байна. ЭМТ-ээс гарч буй эмнэлгийн болон ердийн хог хаягдлыг ангилан ялгаж хэмжээг тодрхойлон, бүртгэл маягтыг журмын дагуу хөтлөж, хүний эрүүл мэндэд хоргүйгээр устгаж байна. Байгууллагын ажилчдын дунд ажлын байран дээр гарч болох эрсдэлийг тодорхойлход эмч мэргэжилтнүүд сумын төвд гадуур тариа хийх, дуудлаганд явган явахад нохойд уруулах эрсдэл байгааг илрүүлэн, иргэдэд эзэнтэй нохойг байнга уяж байх анхааруулсан. Манай байгууллагын ажлын байранд 380w хүчтэй цахилгаан зуух, автклав, ажиллаж байгаа нь хамгийн эрсдэлтэй учир түүнд тохирсон шаардлагатай хамгаалах хэрэгсэл/ унтраалгны хайрцаг, найдвартай газардуулга/-г стандартын дагуу хийж мөн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааварчилгааг мэдээллийн самбарт байршуулсан.. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 73 | 94 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай 2017.01.18 №24 2. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэгт, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Эрүүл мэндийн төв нь шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний дэгдэлтийн үед хариу арга хэмжээ авах бэлэн байдлын өрөө бий болгож, эмийн болон ариутгалын бодисын нөөцийг бүрдүүлж, хамгаалах хувцасны хүртээмжийг сайжруулах зорилгоор 6 хүний хувцасыг шинээр нэмэгдүүлж эмнэлгийн эмч мэргэжилтнүүдэд 7 удаагийн дотоодын сургалтаар тахалын хувцас өмсөж тайлах аргыг зааж сургасан. Өвархангай аймгийн ЭМГ-ын даргын 2022 оны 05 р сарын 09 ны өдрийн А/17 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн цогц үзлэг зохион байгуулан энэ үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалаар баталсан "Сүрьеэ өвчний тусламж үйлчилгээний заавар"-ыг баримтлан үзлэг шинжилгээ зохион байгууллаа. Үзлэгт нийт 192 хүн хамрагдсан. Тухайн үзлэгтээ сүреэгээр өвдөх эрсдэл бүхий иргэд, ахмад настан, сүреэгээр өвдөж байсан иргэний ойрын хавьтал, амьсгалын замын өвчөөр ойр ойрхон өвддөг иргэн, уугшины архаг өвчтэй иргэн, өрхийн амжиргаа муутай иргэд, сумын төвөөс алс зайнд амьдардаг иргэд, өмнө нь сүреэгийн эмчилгээ хийлгэж байсан иргэд зэрэг эрсдэлт бүлгийн иргэдийг хамруууллаа. | 100% | |
| Хэсгийн дундаж 97.5% | | | | | |
| **Нийт үнэлгээ: 95.2%** | | | | | |

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ